

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл



Зургийг Валерий Малеев

2010-2011 онд Баруун Казакстанд болсон соргог бөхөнгийн (*Saiga tatarica tatarica*) хорогдлын шалтгаан

Ричард Кок, Юрий Грачев, Адикай Закыпбаев, Алтай Усенбаев, Стеффен Зутер, Ольга Климанова, Тил Дитерич, Митя Сапанов, Гулмира Изимбергенова

Ахлан бичсэн: Ричард Кок, Их Британий Эзэн хааны мал эмнэлгийн их сургуулийн эмгэг судлал, халдварт өвчний тэнхим, rkock@rvc.ac.uk

Өнгөрсөн 2010 болон 2011 онд Баруун Казахстанд тохиолдсон соргог бөхөнгийн хорогдлын шалтгааныг бэлчээрийн гарцтай холбон тайлбарлаж байна. Учир нь ургамлын гарц, сөл ихтэй байсан нь бөхөнгийн хивэх үйл ажиллагаанд доголдол үүсгэжээ гэсэн таамаглал дэвшүүлж байна. Энэ нь гэдэс хөөх, гүйлгэх зэрэг шинж тэмдгээр илэрч, “Хэнз ногооны халуурал”-тай төстэйгээр олноороо гэнэт үхэх шалтгаан болсон.

Соргог бөхөнгийн хорогдлын шалтгааныг тодруулахад популяцийн алслагдсан байдал, бодгалиудыг ойроос ажиглах боломжгүй, амьтдыг мал эмнэлгийн үзлэгт хамруулах боломжгүй байсан зэрэг хэд хэдэн асуудал сөргөөр нөлөөлсөн.

Соргог бөхөнгийн сэг зэмийг задлан шинжлэх ажил олон цагаар, олон өдрөөр хойшлогдсон тул бактериуд задарч, дүрс хувирч өвчний оношыг будлиантуулж байсан.

Соргог бөхөнгийн популяцид томоохон хэмжээний өвчин дэлгэрч ихээхэн хэмжээний хорогдол гарсаныг түүхэн баримтаас харж болно. Тухайлбал Казахстанд 1955, 1956, 1958, 1967, 1969, 1974, 1981, 1984, 1988, 2010 болон 2011 онд хэд хэдэн өвчний тохиолдол бүртгэгдсэн бөгөөд шүлхий дийлэнх хувийг эзэлж байсан байна. Эдгээр нь өвсөн тэжээлт гэрийн болон зэрлэг амьтдын аль алинд халдварлаж, их хэмжээний хохирол дагуулдаг вирус, бактериар үүсгэгддэг өвчин юм. Хязгаарлагдмал нөөцтэй бөхөнгийн сүрэгт нүүрлэж буй энэхүү халдварт өвчин

Үргэлжлэл 2-р хуудсанд.

Энэ хэвлэлийг ивээн тэтгэсэн:

АГУУЛГА

Гол мэдээ

Ричард Кок болон бусад 2010-2011 онд Баруун Казахстанд болсон соргог бөхөнгийн (*Saiga tatarica tatarica*) хорогдлын шалтгаан..... **1**

Шинэ мэдээ

Элайн Кул ба Кристиане Роемтгер НЗХК-ийн талуудын 10 дахь уулзалт: Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах сүлжээ үүсгэх..... **4**

Надежда Арылова Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний үзэсгэлэнгийн 10 жилийн ой..... **5**

Антони Дансер Оросын өмнөд хэсэгт хийгдсэн бөхөнгийн олон улсын анхны эко аялал..... **6**

Дагмар Андрес-Брьммер Алтын Далад хийгдсэн бөхөн гөрөөсний анхны фото аялал..... **7**

Чингис Минкеёв Бөхөнг хэрхэн харах вэ? Яшкүлийн үржүүлгийн төвөөр аялал..... **8**

Елена Быкова Устюрт тосгонд үзүүлсэн бөхөнгийн тухай баримтат кино..... **9**

Хэвлэлийн мэдээ:
Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах хоёр талын гэрээг бэлдэж байна.

Иргэз-Тургай БНГ-ын захиргааны бүтцийг бий болголоо.
Халимагт хийгдсэн бөхөнгийн судалгаа.

“Бөхөнгийн домог-2” кино Байгалийн кино наадмаас тусгай шагнал хүртлээ.

ТНТ Халимагийн бөхөн хамгаалах хөтөлбөрийг үргэлжлүүлэн дэмжиж байна.

Бөхөн хууль бусаар агнасан тохиолдлууд.

Өгүүллүүд

Бадамжавын Лхагвасүрэн болон бусад Монголын хээр, говь цөлийн хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй дэд бүтцийн нөлөө..... **13**

Баярбаатар Бүүвэйбаатар болон бусад. Монгол бөхөн болон гэрийн малын идэш тэжээлийн давхцал, бүрдэл..... **14**

Самуел Кавенаг Бөхөнгийн нүүдлийн судалгааг хийх ирээдүйн арга зам..... **16**

Сюзанне Офффорд Узбекистанд хэрэгжиж буй мониторинг судалгааны үнэлгээ..... **18**

Карлын Самуел болон бусад Уралын бөхөнгийн популяцид тохиолдсон их хэмжээний үхэл хорогдлын дараа уг популяцийг хамгаалахад олон нийтийн оролцоог бий болгох нь..... **18**

Ольга Переладова ОХУ-ын бөхөн хамгаалах үндэсний төлөвлөгөөг хөгжүүлэх нь..... **20**

Бөхөнгийн баатрууд

Александр Григоряц, Узбекистан..... **21**

Үргэлжилж буй төслүүд

2011 оны БХН-ийн жижиг тэтгэлгийн шалгаруулалт..... **22**

Зарлал

ЗАНЗХК-ийн олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийн зохицуулалт..... **23**

1-р хуудасны үргэлжлэл:

энэ байдлаараа үргэлжилвэл соргог бөхөнгийн сүрэг устаж үгүй болох аюул бодитоор нүүрлэж байна.

Бид Баруун Казахстаны Борсы бүс нутагт 2010 он (~12000 – 15000 амьтан), болон 2011 оны (400+ амьтан) бөхөн цувран үхсэн мэдээллийг өргөн хүрээтэй хэлэлцүүлэг, хээрийн судалгаа болон боломжит мэдээлэл дээр үндэслэн энд дахин хэлэлцүүлж байна. Бидний үндсэн дүгнэлт нь эмгэгийн болон халдварын үйл явцыг харгалзалгүйгээр, үхсэн бөхөнгийн эд эрхтнээс илрэн гарсан өвчин үүсгэгчид үндэслэн шүлхий өвчин гэсэн онош юм. Ерөнхийдөө өнгөрсөн хоёр жилд өвчин дэлгэрсэн тухай мэдээлэл нь бүрэн гүйцэд бус, шийдвэрлэх оношыг тавихад хангалтгүй байсан бөгөөд харин хүрээлэн буй орчны судалгаа ба эсийн дээж, зарим бохирдуулагчаас авсан хорт бодисууд нь тэдгээрийн шалтгааныг тайлбарлах боломжийг бий болгосон. Тухайлбал, дээж цуглуулах арга зүй, үхсэн амьтныг задлан шинжлэх, дээж авах боломж байсан боловч мэргэжлийн хүн дутмаг тул боломж хязгаарлагдмал байсан. Эсийн дээж авах түүний шинжилгээний хариу нь нилээд анхаарал татаж байна.



Борсыгийн эргэн тойрон дахь ургамалжилтыг харуулсан агаарын зураг.

Нэгдүгээрт, 2 жил дараалан тохиосон өвчний хам шинж нь үндсэндээ жилийн адилхан 7 хоногт, ижил газарзүйн байршилд тохиосноороо төстэй бөгөөд 2010 онд нийт популяцийн 75 орчим хувь нь үхсэн байна. Үхлийн эрчим нь 2011 онд адилхан байсан боловч эрүүл газарт байсан 50 орчим тоотой бөхөнгийн сүрэг тухайн газарт шилжин ирсэнээрээ үхэж эхэлсэн нь сонирхол татаж байна (График 1). Тухайн 2 жилд ижил популяцид нөлөөлсөн халдварт өвчний анхдагч шалтгаан ойлгомжгүй бөгөөд шаардлагатай дархлаа бий болсоны дараа дараагийн хорогдлын эрчим буурсан болохыг харуулна. Пастероллэз (уушгины болон цус алдалтын) нь стресс үүсгэдэг хүчин зүйлтэй холбоотой боловч тухайн нутагт нягтшилаас шалтгаалсан эсвэл хүрээлэн буй орчин болон цаг ууртай холбоотой стресс үүсгэх ноцтой хүчин зүйл байгаагүй. Хэдийгээр төллөх нь амьтны хувьд стрессд хүргэх цаг үе ч гэсэн уг нутагт

тухайн жилүүдэд өмнөх жилүүдээс ялгарах ямар нэгэн гоц ялгаа байгаагүй. Нэмж хэлэхэд тухайн нутаг дахь мал сүргийн дунд өвчин дэлгэрсэн тохиолдол байгаагүй. Үхсэн бодгалийн эсээс дээжлэн авсан бактерийн дээж нь биед нэвтрэн орох боломжтой амьсгалын болон ходоод гэдэсний замд байдаг энгийн *Pasteurella*, *Clostridia* байсан. Үхсэн амьтдаас дээж авахдаа хайхрамжгүй хандсан нь эдгээр бактерийн дээжийг задралд хүргэсэн байх талтай.

Эдгээр шалтгаануудын зарим нэгээс харвал *Pasteurella* болон *Clostridia* бактерийн халдвар тодорхой бус бөгөөд ямар тохиолдолд эдгээр организм өвчин үүсгэхэд гол үүрэг гүйцэтгэдэг болох нь эргэлзээтэй юм.



Хоёрдугаарт, энэхүү 2 жилд янзагалах үеийн бөхөнгийн байршил, шилжилт хөдөлгөөн ердийн үеийнхээс өргөргийн дагуу арай хойд зүгт, уртрагийн дагуу арай баруун тийшээ байснаас өөр ямар нэгэн ялгаа ажиглагдаагүй бөгөөд байгаль цаг уурын хувьд өмнөх жилүүдийнхээс харьцангуй дулаан, чийгтэй байсан.

Бие гүйцсэн амьтад тухайн бэлчээрт орсоноос хойш цөөн өдрийн дотор үхэж байхад харин янзаганы хорогдол бага байсан нь шаргачинг үхсэний улмаас өлбөрч үхэх магадлал нэмэгдэж байгаа ажржг чухал ач холбогдолтой ажиглалтуудыг хийсэн байна. Энэ нь жирийн бус халдварт өвчин. Нэг ижил газар нутагт 2 жил дараалан тохиосон хорогдлыг тодорхойлоход **ихээхэн ач холбогдолтой** онцлог нь өвөрмөц байршил-ургамлын бүлгэмдэл болохыг харуулна. Эдгээр нутгийн ерөнхий онцлог нь өндөр нягтшилтай өвслөг ургамал бүхий бэлчээртэй бөгөөд энд хортой ургамалын зүйлүүд болон гэдэс хөөлгөх чадвартай ургамлууд царгас, гичгэнэ мэтийн ургамал ургадаг. Эдгээр зүйлүүд нь үл ялиг хонхор, чийглэг тэжээлээр баян хөрсөнд ургадаг.

Видео, гэрэл зураг болон ажиглалт нь хээрийн бэлчээрт бэлчээрлэх амьтдын амьсгалын болон хоол боловсруулах эрхтний систем өвчилж, эрчимтэйгээр гэдэс нь хөөн гэнэт үхсэн болохыг харуулж байна. Хавар дулахан, чийглэг байсаны үр дүнд тэжээлээр баялаг ургамлууд эрчимтэй ургасан нь бөхөнгийн төллөх үетэй давхцаж хоол боловсруулах эрхтнийг хямруулах эрсдэлтэй идэж тэжээл болсон байна. Хавар болон намрын улиралд тодорхой бэлчээр болон ургамалтай холбоотойгоор гэрийн мал сүрэг ижил шалтгаанаар өвчилдөг байна. Үүнийг заримдаа хэнз ногоотой холбоотойгоор үүсдэг учраас “Хэнз ногооны халуурал” гэж бичдэг (өвсөрхөг газрыг хадланд ашигладаг).

Бөхөнгийн эрүүл мэндэд чиглэсэн шинжлэх ухааныг урагшлуулахад болон цаашид боломжтой оролцоог хангахын тулд дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

- **Ажиглалт** буюу идэвхтэй болон идэвхгүй аргачлалын хослолын зохистой харьцаан дээр үндэслэгдэн хийх хэрэгтэй. Үүнийг ан амьтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран хийж бөхөнгийн эрүүл мэндийг хариуцсан газар, хэлтэс бий болгох



Ширүүн бороотой, ер бусын дулаан температуртай үед орон нутгийн топографийн онцлогтой холбоотойгоор үүссэн баялаг бэлчээрийг онцгойлон, бөхөнгийн төллөлт, шилжилт хөдөлгөөнийг харуулсан 2010 ба 2011 оны Борсы орчмын бус нутгийн бүдүүвч зураг


шаардлагатай бөгөөд мониторинг хэлбэрээр тасралтгүй мэдээлэл цуглуулан мэдээллийн системийг бий болгох шаардлагатай.

- Судалгааны баг нь төллөсний дараа болон төллөх явцад Казахстан дахь бөхөнгийн үндсэн популяцийг судлах, ажиглахад 3-4 долоо хоногийг зарцуулан, улиралтай холбоотойгоор бөхөнгийн томоохон хэмжээний үхэл, төллөлтийн хугацааны талаар талаарх мэдээллийг нэгтгэж, жил бүр мэдээлж байх хэрэгтэй.
- **Судалгаа нь** зан төрх, амьдрах орчин, идэш тэжээл (бэлчээр) зэрэг эрүүл оршин тогтноход шаардлагатай экологийн асуудалд анализ хийн хэвийн, эрүүл байх үзүүлэлтүүдийг бий болгоход чиглэгдэнэ. Өвчин дэлгэрсэн тохиолдолд урьдаас тогтоосон баг иж бүрэн ажиглалт судалгааг яаралтай эхлүүлэх ёстой.
- Өвчин дэлгэрсэн үед **хөндлөнгийн оролцоо нь** өвчний тархалтын байдал, гарах үр дүнд нөлөөлнө.
- Аливаа өвчний эцсийн оношыг тодруулахад

олон төрлийн чадвартай баг шаардагдах бөгөөд хийж болох ялгаатай шинжилгээ ба түргэн шуурхай анализ хийж чадах нөөц бүхий лабораторийн болон холбогдох хүмүүсийн жагсаалтийг гаргасан байх ёстой. Энэ ажилд тохирох олон улсын лабораториуд хамрагдах ёстой.

- **Чадавхи бүрдүүлэх нь хамгийн чухал зүйл юм.** Үүнд олон хүрээлэн оролцох ёстой. Харьяа яаман дээр суурилан бөхөнг хариуцан хамгаалах бүс нутгийн эрдэм шинжилгээний ажилтан эсвэл ерөнхий экологич,

мал эмнэлгийн өвчний тархалтын судлаач эсвэл өвчний экологич, хээрийн нөхцөлд ажиллах малын эмч (хээрийн нөхцөлд ажиллах тоног төхөөрөмж холбогдох зүйлсээр хангагдсан туслах ажилтантай) нэгж байгуулах бөгөөд тэдгээр нь зэрлэг амьтдын эрүүл байдал, өвчлөлийн ажиглалтыг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох шинжлэх ухааны арга ажиллагаа, анализ, хөндлөнгийн оролцоо, хяналт болон менежментийг хэрэгжүүлэхэд дадлагажсан байх ёстой.



Төллөлтийн болон үхсэн нутгуудын ойролцоо хэмжээг харуулсан Борсы дүүргийн газрын зураг (Гил Дейтричийн тодорхойлсноор Охотзоопромын жинхэнэ хувиас сайжруулсан Бакытбек Дысекеевын үйлдсэн зураг (cites@minagri.kz))



Үхсэн бөхөнгийн уналт, хөөлт, хөхрөлт (аспиксна), амьсгалын замаас гарсан цасархаг хөөсийг харуулсан зураг (Охотзоопромын видеоноос гаргасан зураг).

ШИНЭ МЭДЭЭ

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн талуудын 10 дахь уулзалт: Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах сүлжээ үүсгэх

Элайн Куль, Кристиане Роемгер, НҮБХБОХ/ЗАНЗХК Нарийн бичгийн дарга нарын газар



Бөхөн гөрөөс зэрэг нүүдэллэдэг зүйлүүдийн олон улсын хамгааллыг хэлэлцэхийн тулд 80 гаруй засаг захиргааны төлөөлөл 2011 оны сүүлээр Норвегт чуулсан. Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн (ЗАНЗХК) талуудын 10 дахь уулзалтын ерөнхий сэдэв нь

“Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах сүлжээ үүсгэх” байсан. Энэ хурал нь зөвхөн нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалахын тулд газар нутгуудын хоорондох холбоо харилцаа, цөм газар нутгийг таньж тодорхойлоход чухал нөлөөтэй байсан төдийгүй засгийн газраас орон нутгийн иргэд, бүх сонирхогч талуудын хоорондын хамтын ажиллагааг ойртуулах ач холбогдолтой болсон. ЗАНЗХК-ийн хамгаалагч талуудын 10 дахь уулзалтаар баталсан 28 тогтоолын цөөнгүй хэсэг нь бөхөн хамгаалах нийгэмлэгтэй холбогдолтой байсан.

Экологийн сүлжээний 10.3 дахь тогтоол нь нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын экологийн сүлжээг үүсгэх үндэс суурь болох юм. Бөхөн хамгаалалд шаардлагатай цөм нутгуудыг хамгаалах, тодорхойлох түр зуурын болон байнгын үндэс суурь нь Гарын үсэг зурагч талуудын 2 дахь уулзалт (Улаанбаатар, 2010 оны 9-р сар) болон Казахстанд болсон ЗАНЗХК-ийн бөхөн хамгааллын харилцан ойлголцолын санамж бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ЗАНЗХК-ийн хурлаар (Астана, 2011 оны 2-р сар) аль хэдийнэ онцлон авч үзэж бүрдүүлсэн байна.

НҮБХБОХ/ЗАНЗХК нь Норвегийн Арендаль хотод байх НҮБХБОХ-ийн газар (GRID-Arendal) хамтран хамгаалагч талуудын 10 дахь уулзалтын “Амьд ертөнц-холбогдсон дэлхий” хэсэг дээр экологийн сүлжээ зайлшгүй шаардлагатайг онцлон Түргэн хариултын үнэлгээг (Rapid response assessment) танилцуулсан. Бөхөн судлаачдын нийгэмлэгээс бөхөн гөрөөсийг судалгааны маш чухал шалтгаан болгож байгаад талархлаа илэрхийлсэн.

Хэвлэгдсэн бүтээлийн газрын зургийг эндээс чөлөөтэй татаж авч ашиглаж болно:

<http://maps.grida.no/go/collection/living-planet-connected-planet-rapid-response-assessment>

Казахстан, Узбекистан, Монгол зэрэг бөхөнгийн тархалт нутгийн төлөөлөгчид Норвегт хүрэлцэн ирж, шинжлэх ухааны зөвлөл болон хамгаалагч талуудын 10 дахь уулзалтын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцсон. ЗАНЗХК-ийн II хавсралтанд аргаль хонийг (*Ovis ammon*) оруулахыг санал болгосон Киргизстан, Тажикстан зэрэг хөрш зэргэлдээ орнууд мөн оролцсон. Түүнчлэн Төв азийн орнууд идлэг шонхорыг (*Falco cherrug*) ЗАНЗХК-ийн I хавсралтанд оруулах талаарх ажлын хэсэгт идэвхтэй оролцсон. Төв Азийн орнуудын оролцоотойгоор Бухара бугын популяцийг нөхөн сэргээх, хамгаалах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурагч талуудын анхны уулзалт COP10-ын өмнө Бергенд болсон.



Эва Клебелберг, КБТЗХН, Казахстаны бөхөн хамгаалалын туршлага болон хандлагын талаар танилцуулж байна.

Бөхөн гөрөөс болон аргаль хонины хамгааллыг хоёр бүлгийн хурлаар өргөн хүрээтэй хэлэлцсэн. Монголын томоохон туруутан амьтдын нүүдэл шилжилт хөдөлгөөнийг хязгаарлагч хүчин зүйл болж байгаа дэд бүтцийн хөгжлийн асуудалд ШУ-ний зөвлөл болон бүлгийн хурал ихээхэн анхаарал хандуулж байв. Монгол бөхөн болон цагаан зээр зэрэг туруутны нүүдлийн зам, амьдрах орчны тасархайталд төмөр зам болон машин зам зэрэг дэд бүтцийн хөгжлийн үзүүлж буй нөлөөллийн судалгааг ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар танилцуулсан. (Бөхөнгийн мэдээний энэ дугаарт хэвлэгдсэн өгүүллийг хар). Уг судалгааг Монакогоос санхүүжүүлэгдсэн бөгөөд нүүдэллэдэг хөхтөн амьтдад үзүүлж буй дэд бүтцийн сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн дараагийн үйл ажиллагааны эхний алхам болон оролцогчдоо таницуулагдсан.

Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний хамгааллын үзэсгэлэнгийн 10 жилийн ой

Надежда Арылова, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв, arylova@gmail.com

Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс (WCN) жил бүр зохион байгуулдаг зэрлэг амьтан хамгааллын 10 дахь үзэсгэлэн ('Ехро') АНУ-ын Сан Франциско хотод 2011 оны 10 сарын 1-нд болсон. Энэхүү сонирхолтой үйл ажиллагаа нь зөвхөн Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ төдийгүй дэлхий дахины ховордож буй зүйлүүдийг хамгаалах ажил хийж буй бүх талууд оролцсон.

Энэ тэмдэглүүштэй жил Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ байгаль хамгаалах үйлсэд зүтгэж байгаа хүмүүст өөрсдийн хүрсэн амжилт, тэдгээрт тулгарч буй асуудлуудыг тайлбарлах, дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрээс ирсэн донор, сайн дурын ажилтан, судлаачдтай уулзах, хамгийн чухал нь хэдэн мянган километрийн алсад буй адилхан бэрхшээлтэй тулгарч байгаа байгаль орчныг хамгаалж буй бусад хүмүүстэй туршлага хуваалцах, унтрашгүй хүсэл тэмүүлэлтэйгээр өөрсдийн ажлаа хийх тухай Америкийн олон нийтэд хүргэх дахин давтагдашгүй боломжийг олгосон.

Үзэсгэлэнгийн долоо хоногийн турш Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний оролцогч талуудад зориулан доноруудын уулзалт, хурал зөвлөгөөнийг Үзэсгэлэнгийн журамд нийцүүлэн ердийнх шигээ зохион байгуулсан. Анхны хурал дээр Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс залуу судлаачдыг дэмжих хөтөлбөрийн тэтгэлэг авагчдыг танилцуулсан бөгөөд, миний бие ОХУ-ын баруун хойд Пре-Каспийн бөхөн хамгааллын ажлын үр



Кристиане Руттгер, Хайрбек Муссабаев, Мелани Вирту нар Бухара бугын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах хурал дээр.

Шинжлэх ухааны зөвлөлөөр хэлэлцэн батлагдсан Төв Евроазийн хуурай газрын хөхтөн амьтад руу чиглэсэн Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой хэрэгжүүлэх ажлын нэг хэсэг нь бөхөн гөрөөс рүү чиглэгдэж байгаа бөгөөд үүнийг 2012 оны хурлын үеэр бүс нутгийн судлаачдыг оролцуулан хэлэлцүүлж, улам боловсронгуй болгох болно.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.cms.int болон <http://www.cms.int/bodies/COP/cop10/media.htm> -ээс харна уу. Түүнчлэн Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн Төв Азийн бүс нутгийг хариуцсан ажилтан хатаатай Кристиане Роегтер, croetger@cms.int, болон Азийн амьтны аймгийг хариуцсан зөвлөх док Таеж Мундкур, taj.mundkur@wetlands.org нартай холбогдож болно.



Чарли Кновлес Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний тэтгэлэг авагчдыг нийтэд танилцуулж байна.

дүнг танилцуулсан. Бусад улс орнуудаас ирсэн залуу судлаачидтай хамтран албан ёсны хүлээн авалтан дээр, мөн хөтөлбөрийг санхүүжүүлэгч, донорууд болон Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний ажилтнуудтай ярилцаж байхдаа бидний үйл ажиллагааг дэмжиж буй Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний дэмжлэгт чин сэтгэлээсээ талархаж байгаагаа хэлсэн.

Энэ уулзалтанд оролцсон миний хамгийн чухал зорилго нь доноруудтай хэрхэн холбоо тогтоох талаарх практик зөвлөгөө, практик санал зөвлөмж, тэтгэлэгт төсөл бичих ур чадварыг суралцах, гүйцэтгэлийг үнэлэх, бизнес технологийн болон уламжлалт бус мониторингийн аргыг ашиглахад суралцах явдал байсан (үнэрч нохой шиг). Олж авсан мэдээлэл дээрээ тулгуурлан ОХУ-д амжилттай хэрэгжүүлж болохуйц хамгааллын орчин үеийн арга зүйн жинхэнэ практик ойлголтыг олж авсан.

Оройн үдэшлэгийн гоо үзэсгэлэнтэй, хүндэт зочин нь Холливудын алдарт жүжигчин Изабелла Розеллини байсан бөгөөд тэрээр хүрэлцэн ирсэнээр экологичдод урам өгсөн төдийгүй тусламж, дэмжлэг хэрэгтэй амьтны зүйлүүд, тэдгээрийн төлөө хийж буй Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний хамгааллын үйл ажиллагаанд олон нийтийн анхаарлыг эргэлзээгүйгээр хандуулж чадсан. Энэ үйл ажиллагаа албан ёсны бус байсан нь надад маш гайхалтай санагдсан бөгөөд эндээс эхлээд бүх судлаачид шинэ мэдээллийг олж авах, туршлага мэдээлэл солилцох, доноруудтай хувийн харилцаа холбоо тогтоох нөхцлийг бий болгосон.



Зургийн Мартин Варон

Жүжигчин Изабелла Розеллини үг хэлж байна.

Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хамгааллын байгууллагын төлөөлөгч, судлаачид, байгаль хамгаалах үйлсэд зүтгэгч мянга гаруй зочдын хувьд үзэсгэлэнгийн өдрийн гайхамшигтай, сэтгэл хөдөлгөсөн мөч нь энэ байсан. Дэлхий дахинд танигдсан



Зургийн Мартин Варон

Бөхөн хамгаалах нийгэмлэгийнхэн зогсож байна.

байгаль орчныг хамгаалах ажилтан Ян Гүүдаллийн хэлсэн үг гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн. Тэрээр хэлэхдээ: “Жил бүр эдгээр уулзалтанд ирэх нь миний хувьд маш чухал ач холбогдолтой төдийгүй надад урам зориг өгдөг. Бид бэрхшээлээр дүүрэн ертөнцөд амьдарч байна. Энд ирсэнээрээ хүсэл тэмүүлэлтэй, шинжлэх ухаанч маш олон хүмүүсийг, ялангуяа маш их эрч хүчтэй залуу хүмүүсийг олж авч байна”. Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний болон шинээр уригдсан хүчирхэг доноруудын төлөөлөл-байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа хүмүүсийн тавьсан илтгэл маш их сонирхолтой байсан. Хурлын заалан дотор болон үзүүлэнгийн тавиур дээр үзэсгэлэнг үзэж сонирхогчид бүх төрлийн амьтад, тэдгээрийн өвөрмөц экологи, тэдний амьдарч буй улс орны соёл, хүмүүстэй танилцаж байсан.

Бөхөн хамгаалах нийгэмлэг бол Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний хамгийн идэвхтэй хамрагчдын нэг гэдгийг баттайгаар хэлж болно. Зэрлэг амьтан хамгаалах сүлжээтэй хамтран ажилласан хэдэн жилийн хугацаанд тэд бөхөн хамгааллын ажлыг олон улсын түвшинд хүргэх талаар томоохон хэмжээний ажил хийж гүйцэтгэсэн байна. Уг үзэсгэлэн амжилттай болсон бөгөөд бөхөн олон нийтийн зүгээс маш их дэмжлэгийг хүлээн авч, сонирхолыг татаж байв.

Энэхүү 2011 оны үзэсгэлэнд оролцсон нь миний хувьд маш ач холбогдолтой байсан бөгөөд тал хээрийн цорийн ганц энэхүү туруутныг хамгаалах цаашдын үйл ажиллагааг өдөөх шинэ эрч хүчийг надад өгсөн гэдэгт би итгэлтэй байна. Энэ боломжийг ашиглан би энэ үйл ажиллагааг зохион байгуулсан, үүнд оролцох боломжийг бий болгосон Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлж байна.

Оросын өмнөд хэсэгт хийгдсэн бөхөн гөрөөсний олон улсын анхны эко аялал

Антони Дансер, Бөхөн хамгаалах нийгэмлэг SCA, mail@saiga-conservation.com

Бөхөн хамгаалах нийгэмлэгийнхэн 2011 оны 9-р сарын 7-нд бөхөнгийн анхны эко аялалыг амжилттай зохион байгууллаа. Бөхөн хамгаалах нийгэмлэгийнхэн Оросын өмнөд хэсгийн бөхөн хамгааллын төсөлд маш их хэрэгцээтэй байгаа дэмжлэгийг үзүүлэх, түүнчлэн орон нутгийн эдийн засагт орлогын эх үүсвэр бий болгох, өргөн хүрээг хамарсан олон улсын тэтгэлгийн шугамыг бий болгох зорилгоор бүс нутгийн бөхөнгийн тархац нутагт аялал зохион байгуулахаар сүүлийн хоёр жилийн турш ажиллаж байна. Энэ бүхний эцэст Бөхөн хамгаалах нийгэмлэгийнхэн Сага Вояжес орон нутгийн аялалын компанитай хамтран тус нутгийн байгалийн түүх, соёлын өв зэргийг харуулсан 10 өдрийн аялал зохион байгуулсан.

Халимагийн БНУ-ын Ростов-он-Даноос эхлэн Астраханы түүхт хот руу чиглэсэн Хойд Америкийн жуулчдын бүлгийн аялалын зам дагуу Бөхөн хамгаалах нийгэмлэгийн гол гол газруудаар тухайлбал Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв болон Астраханы бүс нутагт дахь Степнойн БНГ-аар аялчилсан. Яшкил тосгоны сургууль, Ростовын биосферийн нөөц газар, Волго Делта дахь усан аялал зэрэг чухал ач холбогдолтой байсан.

Аялалын туршид Ростовын нөөц газрын захирал Людмила Клец, түүний хамтран зүтгэгч Александр



Жуулчид Яшкилийн үржүүлгийн төвд (зүүн) болон Волга мөрөн дээрх усан аялалын үеэр (баруун).

Липкович, Владимир Казмин, Виктор Федосов, Хээрийн амьтад хамгаалах нийгэмлэгийн Виктор Петренко, Юрий Арылов (Зэрлэг амьтан хамгаалах төвийн захирал); болон Анатолий Клуднев (Степной БНГ-ын захирал) зэрэг хүмүүс өөр өөр газраас нийлэн бидэнд газарчлан явсан.

Бөхөн хамгаалагчидтай шууд холбогдож байсан нь аялалаас буцан ирсэн хувь хүний үзэл бодолд маш эерэгээр нөлөөлсөн. Канадаас ирсэн Дебби Чорнейко “Бөхөнд туслахаар оролдож хүмүүстэй уулзахад, тэдний итгэмээргүй үнэнч шударга байдал, хайр халамжийг харахад маш их урам орсон.



Энэ нь надад итгэл өгсөн” гэж саналаа илэрхийлсэн.

Бөхөн хамгаалалыг дэмжих дэс дараалсан, найдвартай урсгалыг бий болгох, Оросын өмнөд хэсгийн биологийн олон янз байдалд учирч буй бэрхшээлд олон улсын анхаарлыг хандуулахад чиглэсэн энэ аялал нь жил бүрийн бааз суурь дээр үргэлжлүүэн хийгдэхийг харуулж байна. Одоогоор дараагийн аялалд бэлтгэж байгаа бөгөөд 2012 оны 8 сард хийгдэхээр төлөвлөж байна. Уг аялалын зар бөхөн хамгаалах нийгэмлэг (БХН)-ийн электрон хаягийн жагсаалт болон БХН-ийн вебсайтад болон олон нийтэд зарлагдах болно.

Хэрвээ та сонирхож байвал mail@saiga-conservation.com хаягаар хандана уу.

Алтын Далад хийгдсэн бөхөн гөрөөсний анхны фото сафари

Дагмар Андрес-Брёммер, Франкфертийн Амьтан судлалын нийгэмлэг, andres-bruemmer@zgf.de

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХН) Номадик Травелтэй хамтран Алтын Дала дахь хамгааллын санаачлага төслийн нутагт анхны “Бөхөнгийн фото сафари” аялалыг 5 сарын 31-нээс 6 сарын 9 хүртэл зохион байгуулсан. Энэ аялал нь Казахстаны Алтан хээрийн байгаль, зэрлэг ан амьтдын аялал жуулчлалын нөхцлийг судлах урьдчилсан төсөл юм. Төслийн цаадах санаа нь сайн төлөвлөгдсөн эко-аялал жуулчлал нь КБТЗХН-ийн зэрлэг амьтдын менежментийг хэрэгжүүлж байгаа нутагт санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгож чадахаас гадна алслагдсан нутгийн хүмүүсийн орлогын эх үүсвэртэй болгоход оршино.

Энэхүү аялалын зорилго нь байгальд дуртай жуулчдыг энэхүү онгон зэрлэг тал нутагт авчрах боломжтой эсэх, мөн энэ нь орон нутгийн иргэд болон байгаль хамгаалалд тустай эсэхийг тогтоох явдал байсан.

Уг аялал нь дэлхий дээрх сүүлийн томоохон зэрлэг онгон нутгийн нэг, хамгийн хол зайд нүүдэллэн бэлчээрлэдэг туруутны нэг болох бөхөн гөрөөснөөс хамааран биологийн олон янз байдал, экосистемээр баялаг Казахын хээр талын төв рүү хийгдсэн. Бетпак-Далагийн бөхөнгийн популяци сүүлийн хэдэн жилийн турш эрчимтэй өсөж байгаа нь тухайн нутагт хийгдсэн анхны аялалыг явуулахад тохиромжтой байсан. Бөхөн аль хэдийн төрж, төллөсөн нутгаа дөнгөж орхиж байсан



Европийн шувуу сонирхогчдын хувьд ховор зүйл болох Каспийн plover-ийг ажиглаж байгаа нь

6 сард аялалыг зохион байгуулсан.

Аялал Зезказган нисэх онгоцны буудлаас эхэлж тэнд дууссан бөгөөд бөхөн судлаач Оркен Шаймуканбетов, КБТЗХН-ийн Эва Клебелсберг, түүнчлэн зэрлэг амьтдын менежментийг хэрэгжүүлж буй нутгийн байгаль хамгаалагчид газарчилсан. Уг баг Улытау руу аялж, хувийн фирмд шөнийг өнгөрөөсөн. Тухайн гэр бүлийн зочломтгой зан гайхалтай байсан бөгөөд орон сууц, хоол унд нь уламжлалт, бодит байсан нь зочдод сайхан сэтгэгдэл үлдээсэн. Аялалын баг маргааш өглөө нь КБТЗХН-ийн зэрлэг амьтдын менежментийг хэрэгжүүлж байгаа нутаг болох Алтыбай руу очин, тэнд 6 өдрийн турш бөхөн болон бусад зэрлэг амьтдыг ажигласан.



Зургийг Дазнар Анорес-Брьонер

Жуулчид чонын мониторинг хийх камер суурилуулахад тусалж байгаа нь

Хээрийн бааз

Бааз нь Улы-Зыланшык голын жижиг тохойн эрэг дээр хот суурин газраас алслагдсан газар байрлаж байсан. Казах хивс, хээ угалзаар чимэглэн тохижуулсан хоёр гэрт байрлуулсан. Орон нутгийн малчдын бүлэг Европ хоолны амттай төстэй уламжлалт аргаар бэлдсэн хоёр Казах хоол авчирсан.

Алтыбай кемпийн эргэн тойронд тал хээрийн маш ховор экосистем харагдаж байсан. Олеастер төгөл нь зэрлэг гахай, саарал чоно болон олон олон зүйл шувуудын хувьд хоргодох орон байр, идэш тэжээл нь болж ашиглагдаж байна. Шувуудын олон янз байдал, нягтшил, ялангуяа Каспийн plover-ийг ажиглаж чадах байсан нь шувуу сонирхогчдын хувьд үнэхээр үзүүштэй зүйл байсан. Жижиг мэрэгчид, мөлхөгчид, тэмээлгэнэ болон цох хорхойн олон зүйлийг ажиглахад хялбар байсан. Чоно, зэрлэг гахай, доргоны мөр болон бөхөнгийн жим хялбархан олдож байв. Экологи болон байгалийг сонирхогч хэн бүхэнд маш чухал газар байсан.

Харагдаагүй бөхөнгүүд

Бетпак-Далагийн бөхөнгийн популяци өсөж байгаа бөгөөд хэдхэн долоо хоногийн өмнө КБТЗХН-ийн “Бөхөнгийн сафари” багийн гишүүд 20000 орчим бөхөнг төллөдөг газрын ойролцоо харсан байна. Энэ нь тохиромжтой амьтдын зургийг авах, сүрэгт дөхөж очих боломжийг нэмэгдүүлсэн. Харамсалтай нь байгаль цаг уурын нөхцөл байдал бөхөнгийн хувьд таатай бус байсан. КБТЗХН-ийн багийн үзэж буйгаар 2011 оны хавар хангалттай их бороотой байснаас шалтгаалан тогтмол устай газруудаар бөхөнгийн сүрэг очих шаардлагагүй байсан. Зургаан өдрийн туршид бид байгаль хамгаалагчдын цөөн хэдэн хоногийн өмнө кемпийн ойролцоо үзсэн домогт “томоохон сүрэг”-ийг олж харахаар хичээсэн. Гэвч бөхөнгүүд олноор болон цөөн тоогоор харагдахгүй байсан. Бид ойролцоогоор 30-40 бодгальтай сүрэгт хэдэн зуун метрийн зайтай ойрхон очсон боловч тэд үргэн тэнгэрийн хаяаны цаад руу давхиад орсон. Эхний хоёр өдөр ширүүн бороо орсноос үүдэн машин замаар явах хүндрэлтэй болсон учраас кемпийн эргэн тойронд хийх өдрийн аялалыг хязгаарлаж байв. Гэвч бид бөхөн харсан. Өмнө нь харсантай харьцуулахад маш бага байсан нь эдгээр амьтад хулгайн ангийн дарамтан дор байсаар байгааг гэрчлэх баримт бөгөөд бид өөрсдийгөө азтайд тооцсон. Ойрын 2-3 жилд буцан хэвийн байдалдаа орох боломжгүй юм.

Аялал жуулчлалын боломж

Алтын-Дала дахь алслагдсан газар нутаг, маш ховор хээрийн ландшафт нь тусгай сонирхлын жуулчдын сонирхлыг татах боломжтой. Хэдийгээр жуулчдын тоо тийм их биш ч гэсэн тэнд байгалийн аялал жуулчлалыг тогтвортой түвшинд хөгжүүлэх нөөц бололцоо бий. Орон нутгийн хүмүүсийн гэрт тэдгээрийг хонуулах, үдийн хоол ундыг хангах зэргээр орон нутгийн хүмүүст орлого орох бүрэн боломжтой.

Цаашид сафариныг янз бүрийн зорилготой жуулчдын бүлгээс хамааран морин болон явган аялал зэрэг бусад үйл ажиллагаатай хослуулах боломжтой. Тахь адуу болон хулан адууг сэргээн нутагшуулахаар төлөвлөж байгаа нь Алтын Далад эко аялал жуулчлалын илүү олон үзмэрийг бий болгох болно. Цаашид, тэнд “чоно ажиглах” аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд чонын популяци нь тухайн нутагт байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нэмэлт үзмэр болох юм. Үүний хажуугаар аялал жуулчлал нь бүс нутгийн хамгаалалд хэрэгтэй зар сурталчилгааг эрчимтэйгээр өсгөж чадна.

*Хэрвээ та тал хээрт бидэнтэй хамт сафари аялал хийхийг сонирхож байвал Ольга Климинова,
Olga.klimanova@acbk.kz хаягаар холбогдоно уу.*

Яшкилийн үржүүлгийн төвд амьд бөхөнг хэрхэн харсан аялал

Чингис Минкеёв, ОХУ, Халимагийн БНУ, Хойд Лидзи-Горьев Тюрбя дунд сургууль

Манай сургуулийн 9-10-р ангийн сурагчид 2011 оны 11- сард биологийн хичээл дээр сурсан бөхөнгийн тухай мэдлэгээ бататгах зорилгоор Яшкилийн үржүүлгийн төвд айлчилсан. Зөвхөн энд хүүхдүүд номон дээрээс уншиж байсан бөхөнгөө өөрийн нүдээр харж, Баруун Хойд Пре-Каспийн бөхөнгийн популяцийн өнөөгийн

байдал, тэдгээрийн тоо толгойн бууралтын шалтгаан, дэлхийн байгалийн өвд бүртгэгдсэн энэ амьтны талаар манай улс юу хийж байгааг мэдсэн. Хүүхдүүд том уужуухан хашаанд бөхөн хэрхэн амьдарч байгааг, үржүүлгийн төвийн ажилчид тэдэнд хэрхэн хандаж байгааг харсан.

Уг төвд бид Халимагийн бөхөнгийн тухай маш их сэтгэл хдөлгөсөн баримтат киног үзсэн бөгөөд бид тус төвийн ажилчдын хийж буй ажлын талаар илүү их дэлгэрэнгүйг мэдэж авсан бөгөөд сонирхолтой асуултуудыг асуун, манай улсын бусад сургуулийн хүүхдүүдийн урласан бөхөнгийн тухай урлагийн бүтээлийг үзэж сонирхсон.

Үржүүлгийн төвийн хашаан дотор байгаа бусад амьтад болох бизон, зэрлэг гахай, тэмээн хяруул, зэрлэг шувууд, тэмээг харахад маш сонирхолтой байсан. Энэ бүхний үр дүнд хүүхдүүд тэдний уугуул нутгийн тухайн маш их сонирхолтой, гайхалтай зүйлүүдийг мэдэж, зөвхөн бөхөн төдийгүй манай улсын болон дэлхий дахины цорын ганц биологийн төрөл зүйлийг хамгаалахад тэдний оролцоо ямар их ач холбогдолтой болохыг ойлгосон. Хүүхдүүд уг аялалд дуртай байсан нь багш нарт маш их ашигтай байсан.

Бид тус хүрээлэнд айлчлах боломжийг өгсөн тус төвийн бүх ажилчдад, тэдний найрсаг угтан авалтанд мөн энэ аялалыг бодитоор зохион байгуулсан бүх хүмүүст талархлаа илэрхийлж байна.



Зургийг Чингис Мемеев

Хойд Лидзи-Горяев Тюрбья дунд сургуулийн оюутнууд Яшкилийн үржүүлгийн төвийн орох хаалган дээр

Устюрт тосгонд үзүүлсэн бөхөнгийн тухай шинэ баримтат кино

Елена Быкова, Бөхөн хамгаалах нийгэмлэг, esipov@xnet.uz

Узбекстанд 2011 оны намар “Шугамын төгсгөлд” нэртэй бөхөн хамгааллын тухай шинэ баримтат киноны нээлт болсон. Уг киног Бөхөн хамгаалах нийгэмлэгийн санаачлага, Канадын *Coins for Change Disney*, Марш Кристианы сан, Олон улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр ГАЛА-Фильм студи бүтээсэн байна. Энэхүү кинонд олон зууны турш Устюртын тал нутагт бие биетэйгээ зэрэгцэн амьдарч ирсэн хүмүүс болон бөхөнгийн хоорондоо хүйн холбоотой хувь тавилангийн тухай өгүүлсэн байна. Уг киног бүтээхэд Жаслык, Каракалпакия болон Кубла-Устюрт зэрэг орон нутгийн бүлэг нөхөрлөлүүд идэвхтэй оролцож, дэмжсэн. Киног бүтээгчид Узбекстан дахь бөхөнгийн хууль бус агнуурын шалтгааныг тодруулан үзсэн бөгөөд энэ амьтны цорын ганц, давтагдашгүй амьдрах орчин, тэдгээрийн биологийн онцлогийг үзэгчдэд танилцуулсан. Уг киногоор одоо хэрэгжиж байгаа байгаль хамгаалах хууль тогтоомж, эдийн засгийн менежментийн уламжлалт арга барил зэрэгт түшиглэн энэхүү тал хээрийн ховор туруутны хамгааллыг хэрхэн дээшлүүлж болохыг харуулсан. Киноны зураг авалтыг Узбекстан, ОХУ-д хийсэн бөгөөд Узбек, Каракалпак, Орос, Англи зэрэг 4 хэлээр орчуулан гаргасан.



Зургийг Анатолий Курочев

Кино найруулагч Галина Виноградова, зураглаач Александр Клепалов нар Астраханы бүсийн зураг авалтын талбай дээр

Киног бүтээгчид уг киног хийхэд тусалж дэмжсэн бүх хүмүүст талархаж байна.

Хэрвээ та уг баримтат киноны хуулбарыг хүлээн авахыг хүсэж байвал esipov@xnet.uz болон mail@saiga-conservation.com хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Хэвлэлийн мэдээ:

Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах хоёр талын гэрээг бэлдэж байна

Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах гэрээнд гарын үсэг зурахаар ОХУ, Казахстан улсууд төлөвлөж байна. Гэрээний анхны хувилбарыг бэлтгэж, Казахстаны БНУ-ын ХАА-н яам, ОХУ-ын Байгалийн нөөц, Экологийн яам гарын үсэг зурахад бэлэн боллоо.

Энэ гэрээ ёсоор тодорхой газар нутгийн бөхөнг ашиглах төлөвлөлт, тэдний нүүдлийн замын чиглэл, уртыг тодорхойлон, мониторинг судалгааны арга зүйг боловсруулах, хил орчмын бүс нутагт тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг хянах зэрэг хамтарсан үйл ажиллагааг явуулах болно. Түүнчлэн талууд уг ховордсон зүйлийг хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг боловсруулж байна.

Илүү дэлгэрэнгүйг доорхи линкээр орж харна уу:
<http://www.newsland.ru/news/detail/id/802756/>,
<http://eco.ria.ru/nature/20111014/458980750.html>.

Иргыз-Тургай БНГ-ын захиргааны бүтцийг бий болголоо.

Казахстаны ХАА-н яам 2011 оны 10 сард Иргыз-Тургай БНГ-ын захиргааны бүтцийг бий болголоо. Иргыз-Тургай БНГ нь 2007 онд байгуулагдсан, Казахстаны хээрийн бүсийг төлөөлсөн анхны тусгай хамгаалалттай газар юм. Уг газар нь Актюбинск мужид 700 мянган га нутгийг хамран оршино. Тус БНГ-ыг орон тооны 99 ажилтантай байхаар шийдвэрлэсэн. Уг БНГ-ын үндсэн зорилго нь Казахстаны хээр талын билэг тэмдэг болох Бетпадалагийн бөхөнгийн популяцийн хамгаалалтыг хангах явдал юм.

Илүү дэлгэрэнгүйг доорхи линкээр орж харна уу:
<http://inform.kz/rus/article/2413477>.

Халимагт хийгдсэн бөхөнгийн судалгаа

Халимагийн БНУ-ын бөхөнгийн газрын судалгааг 2011 оны 10 сарын 22-25-ыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Уг тооллого судалгаагаар амьтны нийт тоо 12870 гэж үнэлэгдсэн нь 2010 оны популяцийн үнэлгээнээс (өөр арга зүйгээр хийгдсэн) 2000-4000 бодгалиар илүү байна. Яам хоорондын уулзалтаар Ан агнуур, амьтны үржүүлгийн Бүх оросын шинжлэх ухаан, судалгааны хүрээлэнгийн Москва дахь салбар, Черные Земли БНГ-аас боловсруулсан арга зүйн дагуу тооллого судалгааг явуулахаар төлөвлөсөн.

Тооллого судалгааг эхлэхээс өмнө БНГ-ын ажилтнууд бөхөнгийн популяцийн өнөөгийн байршлын тухай мэдээллийг цуглуулсан. Энэ мэдээлэл дээр тулгуурлан тооллого явуулах газар нутгийг тодорхойлж, өөр хоорондоо 5 км зайтай 40-65 км урт, хойноос өмнө рүү чиглэсэн 10 параллел шулууны дагуу тооллогыг гүйцэтгэлээ. Тоологч бүр ажиглагдсан бөхөнгийн тоо, цаг, автомашины хурд, трансектын дагуух зай зэргийг бүртгэн тэмдэглэж байсан бөгөөд боломжтой бол сүрэг дэхь бодгалийн нас хүйсний харьцаа, сүрэг хоорондын зай, трансектийн хамгийн эхэнд болоод хамгийн сүүлд тохиолдсон сүргийг бүртгэн тэмдэглэж байсан. Мэдээллийг “Бөхөнгийн үнэлгээ” компьютерийн программ хангамж ашиглан боловсруулсан.

Судалгааны үр дүнд үндэслэн тооллогын комисс тодорхой санал зөвлөмжүүдийг боловсруулсан. Ялангуяа, Халимагийн БНУ-ын Байгалийн нөөц, Хүрээлэн буй орчны хамгаалалын яаманд хүргүүлсэн эдгээр санал зөвлөмжид бөхөнгийн популяцийг хамгаалах зорилгоор Черные Земли БНГ ба Меклектинский ДЦГ-ын дунд болон Артезиан тосгоны ойролцоо хоёр шинэ нөөц газар (ДЦГ)-ыг байгуулах хэрэгтэйг онцолсон байсан. Халимагийн БНУ-ын Байгалийн нөөцийн улсын газар, Байгаль хамгаалалын яам нь хулгайн ангийн эсрэг хамтарсан багийг үүсгэн байгуулах ёстойг мөн зөвлөсөн.

Илүү дэлгэрэнгүйг доорхи линкээр орж харна уу:
<http://savesteppe.org/ru/archives/7447>.

«Бөхөнгийн домог-2» кино Байгалийн кино наадмаас тусгай шагнал хүртлээ.

ОХУ-ын Иркутск мужид “Хүн ба байгаль” нэртэй баримтат, шинжлэх ухааны, боловсролын талаарх олон улсын 10 дахь кино наадам 2011 оны 10 сарын 7-10-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. “Бөхөнгийн домог-2” кино нь хүүхдийн шилдэг хөдөлгөөнт кино ангилалд нэр дэвшиж ялагч болсон.

Уг кино мөн уг наадмыг гол ивээн тэтгэгч болох Мега-Фон гар утасны компаний тусгай шагнал хүртэж, Байгаль-Лена мөрний улсын зэрлэг онгон нутгийн диплом авсан. Зохион бичлэгийн уралдаанд сургуулийн хүүхдүүдийн ирүүлсэн түүх дээр үндэслэн “Бөхөнгийн домог” киног амжилттай үргэлжлүүлэн хийж байна.

Мультифильм студийн захирал Максут Заримбетов (Казахстан) Төв Азийн өнөөгийн амьдралын түүхийг өгүүлж байна. Уг киноны үндсэн санаа нь дэлхийн энэ хэсэгт нэгэн цагт элбэг байсан бөхөн хүмүүсийн үйл ажиллагааны нөлөөгөөр жилээс жилд тоо толгой нь цөөрсөөр байгаа тухай юм. Шагнал гардуулах ёслол дээр Мега-Фон компаний Иркутск мужийг хариуцсан менежер “Уг кино нь зөвхөн уг киног бүтээхэд оролцсон зохиолч нар, мэргэжлийн кино найруулагч нарт төдийгүй хүүхдэд маш чухал ач холбогдолтой юм. Эдгээр боловсрол, мэдлэг олгох, өөрчлөгдөж буй түүхүүд нь ирээдүй хойч үеийнхэнд маш сайн хичээл болох болно” гэж тэмдэглэн хэлсэн.

Илүү дэлгэрэнгүйг доорхи линкээр орж харна уу:
http://www.snews.ru/press_reliz.php?id=31481.



Максут Заримбетов шагнал гардуулах ёслол дээр

ТНТ Халимагийн бөхөн хамгаалах хөтөлбөрийг үргэлжлүүлэн дэмжиж байна.



ТНТ Экспресс компаний Орос дахь салбар 2003 оноос эхлэн Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтныг хамгаалах

төвийн нэг хэсэг болох Яшкилийн үржүүлгийн төвийг дэмжих үйл ажиллагааг явуулж эхлэсэн. (Бөхөнгийн мэдээ-3 дугаарыг хар). Компанийн захирал Карро ван Греефландын санаачилгаар 2011 оны 10 сард 300000 рублийн тэтгэлгийг тус төвийн малын идэш тэжээл худалдан авах, шатахуун тос, засвар, хашаа томруулах болон бусад зардалд зориулан өгсөн. ТНТ-ийн хандив, тусламж урин дулаан цагт бус, амьтныг халамжлах, тэжээх, хамгаалахад илүү их хөдөлмөр шаардагддаг өвлийн улиралд ирдэг байна. Өнөөгийн байдлаар, тус үржүүлгийн төвд 2011 оны хавар төрсөн 26 янзагыг оруулаад нийт 76 бөхөн эсэн мэнд бойжиж байна. Ноён ван Греефландын үзүүлж буй тусламж, дэмжлэгийг өндрөөр үнэлэн Халимагийн засгийн газрын хүндэт жуух бичгээр шагнасан. *Илүү дэлгэрэнгүй мэдээллийг "Известия Калмыкии" сонины 2011 оны 10 сарын 22-ны өдрийн дугаараас харна уу.*

Бөхөн хууль бусаар агнасан тохиолдлууд

Устюртын популяци

2011 оны 8 сарын 19

Казахстаны Актюбинск мужид зугтааж байгаа 3 жийп машиныг илрүүлсэн. Эврийг нь хөрөөдсөн 4 бөхөнгийн гулууз олсон. Дотоод явдлын яаманд бүртгэгдсэн энэ гэмт хэргийг шалгах ажиллагаа үргэлжилж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://kt.kz/?lang=rus&uin=1133167994&chapter=1153543930>.

2011 оны 8 сарын 28

Узбекистаны Ташкент муж дахь Гишт-Куприк гаалийн газарт бие гүйцсэн бөхөнгийн хос эвэр, бугын эвэр хураагдсан. Казахстаны Фергана хөндийн оршин суугчид хот руу орохдоо авч явсан байна. Уг хэрэг мөрдөн байцаалтын шатанд байна.

2012 оны 12 сарын 27

Улсын биологийн хяналтын газар, Амударья мужийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар (Узбекистаны БНУ-ын Байгалийн нөөцийг хамгаалах үндэсний хорооны харьяа) Узбекистаны Каракалпакстан мужийн Муйнак дүүрэгт бөхөнгийн хулгайн анчдын бүлгийг саатуулсан. Залуу эм бөхөнгийн шулсан гулууз махыг эд мөрийн баримт болгон хураан авсан. Муйнак дүүргийн оршин суугчид болох хулгайн анчдыг саатуулах үед эсэргүүцэл үзүүлсэн. Аралын байгаль хамгаалах олон нийтийн прокурорын газар эд мөрийн баримтыг хураан авч, мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлж байна. Хулгайн анчдын машин, хоёр бууг Дотоод явдлын яамны дүүргийн хэлтэс хураан авсан.

Мөн өдөр 67 хос бөхөнгийн эврийг авч явсан

Узбекистан улсын иргэнийг Самарканд хотын төмөр замын өртөөн дээрээс саатуулсан. Хууль бус ачааг төмөр замын цагдаагийн газар хураан авч Амьтан, Ургамлын аймгийг хамгаалах мэргэжлийн хяналтын газарт магалдан шинжлүүлэхээр шилжүүлсэн байна. Энэ хэрэг Самарканд хотын тээврийн прокурорын газарт шалгагдаж байна.



Зургийг: Узбекистаны БНУ-ын улсын биологийн хяналтын газар

Самаркандад хураагдсан бөхөнгийн эвэр.

Бетнакдалагийн популяци

2011 оны 9 сарын 25

Охотзопром агнуурын менежментийн байгууллагын ажилтнууд Казахстаны Актюбинск мужийн Иргиз дүүрэгт хоёр хулгайн анчныг саатуулсан. Тэдэнд 2 хос бөхөнгийн эвэр, спорт агнуурын буу байсан. Тэднийг саатуулсан газраас холгүйхэн эврийг хөрөөдөн авсан 2 бөхөнгийн гулууз олдсон. Энэ хэргийг Эрүүгийн хуулийн 288-р зүйл ангид заасны дагуу шийдвэрлэсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://www.newskaz.ru/incidents/20110929/1950792.html>.

2011 оны 10 сарын 20

Байгаль хамгаалах цагдаагийн газар өөрсдийн явуулсан ажиллагааны дүнд Казахстаны Сыр Дарья мужийн Теренозек тосгоны оршин суугчид болох хулгайн анчид хууль бусаар бөхөн агнасан болохыг илрүүлж саатуулсан. Цагдаа нар 5 бөхөнгийн гулууз, хулгайн анчдын сумыг олсон. Уг хэргийг Эрүүгийн хуулийн 288 зүйл ангиар шийдвэрлэсэн. *Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:*
http://www.kazakh-zerno.kz/index.php?option=com_content&view=article&id=46398:2011-10-20-05-13-10&catid=14&Itemid=80

2011 оны 11 сарын 17

Казахстаны Кызылорда, Караганда мужийн хил дээр, хүрээлэн буй орчны цагдаа, Охотзопром агнуурын менежментийн байгууллагын хамтарсан ажиллагаагаар 31, 38 настай Караганда мужийн хоёр иргэн бөхөн хууль бусаар агнасныг илрүүлж баривчилсан. Бөхөнгийн гулууз мах, сумтай спорт агнуурын буу тэдний машинаас олдсон. Энэ хэрэг Эрүүгийн хуулийн 288 дугаар зүйл ангиар шийдвэрлэгдэх болно. *Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:*
<http://today.kz/ru/news/incident/2011-11-17/54344>

2011 оны 12 сарын 29

Казахстаны Актюбинск мужийн дотоод явдлын газрын Иргиз дүүргийн ажилтнууд Кызылорда мужийн Саксаул хотын харъяат хоёр иргэн Иргиз мужийн Бестоуб нутгаас бөхөн хулгайгаар агнасан болохыг илрүүлсэн. Цагдаагийнхан тэдний Toyota Land Cruiser маркийн машины зорчигчийн тасалгаанаас зөвшөөрөлгүй хоёр амтай спорт агнуурын бууг олж, хураан авсан. Машин ирсэн зам дагуугаас эврийг хөрөөдсөн 5 бөхөнгийн гулузыг олсон. Энэ хэрэг Эрүүгийн хуулийн 288-р зүйл ангиар шалгагдаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://inform.kz/rus/article/2429757>

2011 оны 1 сарын 6

Хүрээлэн буй орчны цагдаа, Охотзопром агнуурын менежментийн байгууллагын хамтарсан шалгалтаар Кызылордагаас 120 км зайд Toyota Land Cruiser маркийн машиныг саатуулсан. Бартаат замын машины ачааны хэсгээс 3 бөхөнгийн гулууз, зорчигчдын тасалгаанаас спорт буу, сумнууд олдсон. Хулгайн ангийн бүлэгт Кызылордагийн 4 оршин суугч, Шиели дүүргийн 1 хүн байсан. Кызылордагийн Дотоод явдлын яамны хэлтэс уг гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 288 зүйл ангиар ял үүсгэн шалгаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://inform.kz/rus/article/2431127>

2011 оны сүүл-2012 оны эхэн үе

Цагдаагийн 5 ажилтан Казахстаны Кызылорда мужид бөхөн агнасан 2 тусдаа үйлдэгдсэн хэргийг илрүүлсэн. Хүрээлэн буй орчны цагдаагийн ажилтнууд 2011 оны 12 сарын 30-нд Кармакши дүүрэгт сэжиг бүхий бартаат замын 2 автомашиныг саатуулсан. Машинд 3 хүн байсны нэг нь Залагаш дүүргийн дотоод явдлын хэлтсийн орлогч дарга байсан. Машинаас 26 бөхөнгийн гулууз мах олдсон. Сырдарьяа мужийн дотоод явдлын хэлтсийн ажилтнууд 2012 оны 1 сарын 14 нд Кумкол тосгоны орчим машин саатуулж, ачааны хэсгээс 32 бөхөнгийн гулууз мах олсон. Машинд Кызылорда дүүргийн 2 оршин суугч байсны нэг нь Дотоод явдлын хэлтэст ажиллаж байгаас 2006 онд, нөгөөх нь 2010 онд халагдсан хүмүүс байсан. Хуулийн хянан шалгах үйл ажиллагаа эхэлсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://www.caravan.kz/article/40313>,
<http://inform.kz/rus/article/2434028>

Орос/Казахстаны хил

2011 оны 11-12 сар

Атыраугийн цагдаагийн газар, хилийн харуулынхан 2011 оны сүүлийн долоо хоногт ОХУ-аас Казахстан руу бөхөнгийн эвэр хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан 3 тохиолдолыг илрүүлсэн. Бөхөнгийн эврийг хууль бусаар хил нэвтрүүлэх эдгээр тохиолдлууд улам бүр ихсэж байгаа бөгөөд Казахын гаалийн албаны ажилтнууд уг эврийн уугуул нутаг болох Оросын талынхантай хамтран энэ үйлдлийн шалтгааныг илрүүлэхээр ажиллаж байна. Гэмт хэргийн бүлэглэл Астраханы бүсэд бөхөн хулгайгаар агнасан байх боломжтой юм.

Казахстаны Курмангаз дүүргийн Шеп шалган нэвтрүүлэх цэг дээр 11 сарын 28 нд хилийн цэргийнхэн

Астраханы (Орос) иргэний жолоодсон ОХУ-ын улсын дугаартай Toyota машиныг саатуулсан. Машинаас 93 бөхөнгийн эвэр хийсэн уут олсон. Жолоочийн гэрчилж буйгаар Өмнөд Казахстаны бүс нутгийн харъяат зорчигчийнх болох тухай хэлж байв.

Курмангаз дүүргийн дотоод явдлын яамны хэлтсийн ажилтнууд болон хилийн харуулынхан 11 сарын 30-нд Байда тосгоны ойролцоо Орос-Казахстаны хилээр нэвтэрч явсан машиныг зогсоосон. Өмнөд Казахстаны харъяат, 51 настай зорчигч 177 бөхөнгийн эвэр тээвэрлэж явсан.

Шеп шалган нэвтрүүлэх цэгт хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого 2011 оны 12 сарын 1-нд гарсан. Цагдаагийн ажилтнууд Астраханы харъяат иргэний жолоодсон машиныг зогсоон шалгахад өмнөд Казахстаны 20 настай иргэний авч явсан ачаанаас 46 бөхөнгийн эвэр бүхий уут олсон. Гэмт үйлдлээ нуун далдлахын тулд цагдаагийн ажилтнуудад 5000 тэнгэ болон 1000 рублийн хахууль өгөхийг оролдсон. Энэ хэрэг Казахстаны эрүүгийн хуулийн 183-р зүйлд заасан хориотой бараа хил нэвтрүүлэхийг завдсан, хахууль өгөхийг оролдсон зэрэг зүйлүүдээр эрүү үүсгэгдсэн шалгагдаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:
<http://inform.kz/rus/article/2423696>,
<http://www.volgograd.kp.ru/online/news/1029132/>,
http://caspionews.kz/?p=8476_and_others.

Хятад

2011 оны 10 сарын 01

Манжуурын гаалийн ажилтнууд ОХУ-аас Хятад руу 6 бөхөнгийн эвэр хил нэвтрүүлэхийг завдсан Хятад улсын харъяат иргэнийг саатуулсан. Тэр хүний ачааг гаалийнхан шалгаж байх явцад нэг ажилтан сэжиг бүхий шовх үзүүртэй зүйлийг анзаарсан байна. Энэ хэрэг одоогоор мөрдөн байцаалтын шатанд байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр орж авна уу:

<http://www.chita.ru/news/33468/> болон
http://legal.gmw.cn/2011-10/01/content_2728912.htm.



Зургийг: Кызылорданы дотоод явдлын хэлтсийн хэвлэлийн газар



Photo by АСВК

Казахстаны Караганда мужид машины ачааны хэсгээс олдсон бөхөнгийн гулууз(зүүн). 2011 оны зун Казахстаны Актаугийн гудамжийг дүүргэсэн байсан «Би хөгшин бөхөнгийн эврийг худалдаж авна» гэсэн зар (баруун).

ӨГҮҮЛЛҮҮД

Монголын хээр, говь цөлийн хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй дэд бүтцийн нөлөө

Б.Лхавгасурэн, Б.Чимэддорж, Д.Санжмятав

ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, lkhagvasuren@wwf.panda.org, chimeddorj@wwf.panda.org

Дэлхий дээрх олон амьтны зүйлүүд улирлын уур амьсгалын өөрчлөлт, идэш тэжээлийн хангамжийн солигдлоос шалтгаалан бүтэн жилийн зөвхөн нэг хэсэгт ашигладаг амьдрах орчинтой байдаг. Амьтны зүйлүүдийн амьдралын түүхээс дамжин ирсэн хол зайд хийх шилжилт хөдөлгөөн нь амьдрах орчны тасархайтал, шилжилт хөдөлгөөнд нөлөөлж буй хүнээс улбаатай хязгаарлагч хүчин зүйлүүдэд илүү эмзэг байж магадгүй юм. Төмөр зам, машин зам болон хий дамжуулах хоолой зэрэг шугаман байгууламжууд нь зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт, эсэн мэнд үлдэлтэнд чухал нөлөөтэй байдаг. ЗАНЗХК-оос нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалалд эн тэргүүний холбогдолтой шилжилт хөдөлгөөнийг хязгаарлагч хүчин зүйлүүдийг тодорхойлсон байдаг. Төв Азид, ялангуяа Монгол оронд төлөвлөгдсөн болон баригдаж буй томоохон дэд бүтцийн төслийн тоо (төмөр зам, уул уурхай, дамжуулах хоолой, хилийн шугам гэх мэт) сүүлийн хэдэн жилд эрчимтэйгээр өсөж ирлээ.


Төлөвлөгдсөн болон одоо хэрэгжиж буй дэд бүтцийн төслийн тоо үндсэндээ илэрхий байх ба Монголын газар нутгийн ихэнх хэсгийг хамруулан холбосон (тухайлбал Монголын засгийн газар, Азийн хөгжлийн банкны замын сүлжээг хөгжүүлэх төслөөс хэрэгжүүлж байгаа Мянганы зам) бөгөөд нүүдэллэдэг зүйлүүдэд үзүүлж буй эдгээр төслүүдийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ нь нүүдлийн замыг хадгалах, амьдрах орчны бүрэн бүтэн байдлыг хангах, хамааралтай хууль эрх зүйн бодлогын дэвшилийг бий болгоход чухал үүрэгтэй.

Монголын хуурайн газрын хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй шугаман дэд бүтцийн нөлөөллийг задлан шинжилж, судалгаа хийхээр НҮБХХ/ЗАНЗХК нь ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран ажиллахаар зөвшилцсөн. Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцид бүртгэгдсэн хар сүүлтий (*Gazella subgutturosa*), цагаан зээр (*Procapra gutturosa*), хулан адуу (*Equus hemionus*), монгол бөхөн (*Saiga borealis*) зэрэг нүүдэллэдэг зүйлүүдэд үзүүлж буй өнөөгийн дэд бүтцийн нөлөөллийг тодорхойлох, эдгээр зүйлүүдэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах тохиромжтой арга зам болон зөвлөмжүүдийг боловсруулах ажил зайлшгүй шаардлагатай юм. Эдгээр зүйлүүдийн цөм байршил нутгийг дайран өнгөрөхөөр төлөвлөгдсөн машин болон төмөр замын байгууламжуудын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авахгүй бол тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлагч томоохон хүчин зүйл болох болно.

2025 онд дуусгахаар төлөвлөгдсөн төмөр замын бүтээн байгуулалтын дараа цагаан зээрийн

популяци төмөр зам болон тороор хашигдсан 9 тусгаар популяци болон задрах бол хулан адуу, хар сүүлтийн популяци 5 болон 7 салангид популяцид хуваагдах болно. Монгол бөхөнгийн популяци 2 тусгаар популяцид хуваагдах болно.


Өндөр ачаалалтай тээврийн зам, урт хашаа нь өндөр ач холбогдолтой идэш тэжээлийн нөөц бүхий газарт хүрэх болон уг газарт тойруу замаар явж хүрэхэд хязгаарлагч хүчин зүйлүүд болсноор том туруутан амьтдын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлана. Эдгээр хязгаарлагч хүчин зүйлүүд болон амьдрах орчны тасархайтал нь “ирж буй” ган, хатуу ширүүн өвлийн улиралд арай дээр газар луу нүүдэллэн шилжих зэрлэг амьтдын популяцийн чадавхийг бууруулна. Энэ бүхнийг тооцолгүйгээр зүйлийн гадаад болон дотоод өрсөлдөөн нэмэгдсэний үр дүнд сул дорой биетэй бодгалиуд олноор бий болж үхэл хоргодол ихсэх болно.



Монголын уур уурхайн газар, 2011, ДБХС, 2011

Газрын зураг 1.

Монгол орны стратегийн чухал ач холбогдолтой орд газруудын байршил.



Монголын төмөр зам компани, 2011 & WWF Mongolia, 2011

Мар 2.

Монголын нүүдэллэдэг туруутан амьтны амьдрах орчныг дайран өнгөрсөн болон төлөвлөгдөж байгаа төмөр зам нь туруутны популяцийг жижиг тусгаарлагдсан популяциудад хуваах болно.

Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ ба зөвлөмжүүд

Цагаан зээр, хар сүүлтий, хулан адуу зэрэг нүүдэллэдэг зүйлүүдэд эдгээр дэд бүтэц хамгийн ихээр нөлөө үзүүлэх болохыг судалгааны дүн харуулж байна. Хэдийгээр монгол бөхөнгийн тархац нутгийг дайруулан 2025 он гэхэд машин зам болон төмөр зам тавихаар бодлогын баримт бичигт төлөвлөгдсөн байгаа ч өнөөгийн байдлаар уг амьтны популяци, тэдгээрийн тархац нутгийн хүрээнд дэд бүтцийн хөгжлийн нөлөө ажиглагдахгүй байна.

Монголын уул уурхай болон дэд бүтцийн хөгжилд оролцож буй төрийн болон төрийн бус байгууллага, үндэсний болон олон улсын байгууллагууд Монголын өнөөгийн түүхэнд тохиолдож буй менежментгүй, алдааг давталгүйгээр өөрсдийн бүтээн байгуулалт, хэрэгжүүлж буй төслүүдэд зэрлэг амьтанд тохиромжтой нөхцлийг харгалзан үзэх ёстойг судалгааны үр дүнд үндэслэн зөвлөж байна.

Нарийвчилсан биологийн төрөл зүйлийн үнэлгээ нь тухайн нөлөөлөлд өртөж буй бүс нутагт урт хугацааны биологийн төрөл зүйлийн мониторинг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бий болгоход үндсэн бааз суурь болох болно. Хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээ нь (EIAs) аливаа дэд бүтцийг бий болгохоос өмнө зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн, цөм байршил нутаг, улирлын эзэмшил нутгийг хамруулан хийгдсэн байх ёстой. Зайлшгүй нөлөөллийг бууруулах, биологийн



Зургийг Вадим Кириллов

Төрөн хашаанд орооцолдсон цагаан зээр

төрөл зүйлийг нөхөн сэргээх ажлыг анхааран төлөвлөсөн байх ёстой. Нүүдэллэн өнгөрдөг гол газруудад дээгүүр болон доогуурх нүхэн гарцыг байгуулах зэргээр сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн тохиромжтой арга хэмжээг сайтар боловсруулсан зааварчилгаа байх ёстой. Хэрвээ зайлшгүй байдлаар хашаа барих бол зэрлэг амьтан төмөр замыг тогтмол огтлон гардаг газруудыг хашаалахгүй үлдээж, зөвхөн хүн малын нягтшил өндөртэй газарт хашааг барих ёстой. Хэрвээ хашааг барьсан бол төмөр утасны дээд болон доод талын шугам өргөсгүй байх ёстой.

Энэ өгүүлэлтэй холбоотой дэлгэрэнгүй тайланг доорх хаягаар үзэх боломжтой.:

http://www.cms.int/bodies/ScC/17th_scientific_council/Inf

Редакторын тэмдэглэл: Вилсон, Реедер нарын ангиллын дагуу ЗАНЗХК болон ЗАХЗОУХК-ийн II хавсралтад бүртгэгдсэн *S.t.tatarica* дэд зүйлийн оронд *Saiga tatarica*, *S.t. mongolica* дэд зүйлийн оронд *Saiga borealis* дэд зүйлийг оруулж шинэчилсэн болно. Үүнээс хойш бид монгол бөхөнг *S.borealis* дэд зүйлд хамруулах болно. Гэсэн ч энэ шийдвэрийг гарах нотолгоог бүрэн шалгах хэрэгтэй. Бид Бөхөнгийн мэдээний дараагийн дугаарт энэ асуудлыг хөндсөн өгүүлэл оруулахаар төлөвлөж байна.



Зургийг Вадим Кириллов

Хашаагаар тусгаарлагдсан цагаан зээрүүд давхиж байгаа нь

Монголын бөхөн болон гэрийн малын идэш тэжээлийн давхцал, бүрдэл

Баярбаатар Бүүвэйбаатар, Гүндэнсамбуу Гүнбат, Тодд К.Фуллер

Өгүүллийг: Баярбаатар Бүүвэйбаатар, АНУ, Массачусетс муж, Амхерстийн их сургууль, Хүрээлэн буй орчны хамгааллын тэнхим, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Монгол улс, Улаанбаатар, bbayarba@eco.umass.edu

Гэрийн мал болон зэрлэг туруутны идэш тэжээл болон усны төлөөх өрсөлдөөний нөлөөллийг сонирхох дэлхий нийтийн хандлага улам бүр ихсэж байна. Энэ нь уламжлалт мал аж ахуй эрхлэн ирсэн Монголын нөхцөлд түүнчлэн цагаан зээр (*Procapra gutturosa*), хулан адуу (*Equus hemionus*), аргаль хонь (*Ovis ammon*), монгол бөхөн (*Saiga borealis*) зэрэг өвсөн тэжээлт амьтад дээр илэрч байна. Баруун Монголын цөлөрхөг хээрт орших монгол бөхөнгийн популяцийн хэмжээ 5000-7000 бодгаль гэж үнэлэгджээ. Хэдийгээр харьцангуй сайн хамгаалалттай улмаас хулгайн анд өртөх нь харьцангуй бага боловч Монгол орны малын тоо толгой өсөж, бэлчээрийн даац багасаж байгаа нь тулгарч буй гол бэрхшээл юм. 1990-ээд онд мал сүргийг хувьчилснаар

малын тоо толгой эрс өссөн бөгөөд өнөөгийн байдлаар бөхөнгийн тархац нутаг дахь малын биомассын харьцаа бараг 50:1 байна. Малын тоо толгой сүүлийн үед өссөнөөр идэш тэжээлийн болон хөндлөнгөөс ирж буй өрсөлдөөн нэмэгдэж, бөхөнгийн тогтвортой оршин байх боломжтой амьдрах орчин улам бүр багассаар байна. Хэдийгээр мал аж ахуй нь Монгол орны чухал ач холбогдолтой үйлдвэрлэлийн нэг боловч маш сайн мал аж ахуйн менежментийг төлөвлөн бэлчээр нутагт тогтвортой хэрэгжүүлж эхлэх нь экосистемд, түүнчлэн бөхөнд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чухал нөлөөтэй юм. Энэ нь монгол бөхөн болон гэрийн малын идэш тэжээлийн давхцал, хоол тэжээлийн онцлогийг судалсан анхны судалгаа юм.


Бид баруун монголд Шарга БНГ-т бөхөн болон гэрийн малын хоорондох идэш тэжээлийн өрсөлдөөнийг судалсан (Зураг 1). Бөхөн болон гэрийн малын (ямаа, хонь, адуу, тэмээ) шинэ хорголыг цуглуулан ургамлын үлдэгдлийг анализд ашигласан. Ургамлыг хялбар тодорхойлох, дээжүүдийг лавлахын тулд үндсэн идэш тэжээлийн ургамлын нахиаг ашигласан. Баасны анализыг дижитал микроскопын тусламжтайгаар гүйцэтгэсэн. Идэш тэжээлийн бүрэлдхүүний давхцалын зэргийг Пианкагийн давхцлын индекс (OI)-ыг ашиглан тооцоолсон. Утга нь 0-тэй тэнцүү бол давхцал байхгүй, 1 гэсэн утга нь давхцалтай байгааг харуулна.

2010 оны зуны турш 35 эмэгчнээс төрсөн 36 янзагыг (1-3 хоногтой) барьж, тэдгээрийн мэнд үлдэлт, шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны сонголтыг танин мэдэхийн тулд нэг удаагийн хэрэглээний 70 грамм жинтэй VHF радио хүзүүвчийг зүүсэн (Зураг. 2). Амьтан барих арга зүйг Массачусетсийн Амхерстийн их сургуулийн Амьтан анагаах, ашиглах шинжлэх ухааны хүрээлэнгээр батлуулсан.

Долоо хоногт 3-4 удаагийн давтамжтайгаар телеметрийн судалгаа хийж хүзүүвчилсэн бүх янзагыг хянаж байсан. 2010 оны 6 сарын 10-наас 8 сарын 20 хүртэлх хугацаанд Шаргын БНГ-ын дотор болон гадна бөхөн ажиглагдаж байсан нутагт бөхөнгийн янзаганы амьдрах орчны сонголтыг танин мэдэх үүднээс 105 сорилын талбайг сонгон авч тэмдэглэсэн (зураг. 1). Талбай тус бүр 1 м² хэмжээ бүхий 5 зэрэгцээ квадрат хуваагдах бөгөөд түүн доторхи ургамлуудаас дээж авсан. (n = 525 квадрат). Талбайд тохиолдож байсан ургамлын зүйл тус бүрийн давтамж, тохиолдоцийн хувийг тооцоолон гаргасан.

Ургамлын сорилын талбайд бутны 5 зүйл, 6 өвсөрхөг зүйл, 14 зүйл өвслөг ургамал бүхий нийт 25 зүйл ургамал бүртгэгдсэн. Таана, хөмөл (*Allium polyrrhizum* ба *A. mongolicum*) нь хамгийн түгээмэл тохиолдож байв. (525 талбайн 432 талбайд). Хамгийн элбэг тохиолдож байсан 5 зүйлээс (тохиолдоцийн хувь >40%), 3 зүйл нь өвслөг ургамал баглуур, таана, хөмөл (*Anabasis brevifolia*, *Allium polyrrhizum* and *A. mongolicum*), говийн хялгана (*Stipa gobica*) нэг зүйл шарилж (*Artemisia sp.*) байсан.

Тэмээний хорголын бүрэлдэхүүн нь бусад туруутан амьтадтай харьцуулахад хамгийн ялгаатай нь байсан. (хүснэгт 1). Тэмээ нь бут сөөгөөр давамгайлсан хооллох бөгөөд баасны 49%-ийг нь бутархаг ургамлын зүйлүүд эзэлж байсан. Сонгины төрлийн ургамал бөхөн, ямаа, хонины хорголд бусад ургамлаас илүү их хэмжээтэй байсан (19-27%) бол хялганы төрлийн өвсөрхөг



Зураг 1.
Баруун Монголд хийгдсэн судалгаанд хамрагдсан нутаг болон ургамлын дээж авсан цэгүүд

Хүснэгт 1.
Баруун Монголын амьтны идэш тэжээлийн давхцалын хоорондох Пианкагийн индекс

	Бөхөн	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ
Бөхөн	--				
Хонь	0.96	--			
Ямаа	0.95	0.98	--		
Адуу	0.88	0.92	0.96	--	
Тэмээ	0.73	0.78	0.71	0.78	--

ургамал адууны баасанд илүүтэй илэрч байсан (32%). Хэдийгээр баглуур нь ургамлын сорилын талбайд танаа, хөмөл болон говийн хялганы (Хүснэгт 1) дараа тохиолдож байсан 3 дахь элбэг тохиолдоцтой ургамал байсан боловч энэ ургамал зөвхөн бөхөн болон тэмээний баасанд 10% ба 12%-ийг эзэлж байсан. Шаргын говь дахь монгол бөхөнгийн идэш тэжээлийн бүрдэл нь хонь (OI = 0.96), ямааныхтай (OI = 0.95) бараг төстэй боловч адуу (OI = 0.88) болон тэмээнийхээс (OI = 0.73; Хүснэгт 1) ялгаатай байсан. Идэш тэжээлийн давхцалын хамгийн бага утга ямаа болон тэмээний хооронд (OI = 0.71) илэрч байгаа бол ямаа, хонины хооронд идэш тэжээлийн хамгийн их давхцал (OI = 0.98; Хүснэгт 1) ажиглагдана.



Баруун Монгол дахь идэшилж буй бөхөнгийн сүрэг

Зургийг Гүрэнсамбуугийн Гүндэн

Хэдийгээр Монгол орны бусад хэсэгтэй харьцуулахад судалгааны талбайн ургамлын зүйлийн олон янз байдал бага боловч бөхөн нь тэжээллэг чанар өндөртэй ургамал болох таана, хөмөл (*Allium spp*) болон баглуур (*Anabasis brevifolia*)–г идэш тэжээлдээ сонгон хэрэглэдэг болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Цаашилбал, монгол бөхөнгийн идэш тэжээлийн бүрдэл нь хонь болон ямааныхтай бараг адилхан боловч адуу, тэмээнийхээс ялгаатай байгаа нь идэш тэжээлийн нөхцөл хязгаарлагдмал үед бөхөн болон зарим нэг мал сүргийн хооронд идэш тэжээлийн төлөөх өрсөлдөөн ихсэж болзошгүйг харуулна. Өмнөговь болон Дорноговь аймагт цагаан зээр болон аргаль хонин дээр хийгдсэн ижил төстэй судалгааны үр дүн нь мөн ялгаагүй гэрийн малтай, ялангуяа ямаа болон хоньтой харьцангуй их өрсөлдөөнд ордог болохыг харуулсан. Эндээс үзвэл ховордсон бөхөн гөрөөсийг хамгаалах бэлчээрийн менежментийн үзэл санаа нь намрын улиралд бөхөн нутагладаг гол газруудад хонь ямаа бэлчээхээс татгалзах нь зүйтэй юм. Энэ нь идэш тэжээлийн өрсөлдөөнийг багасгаж, бөхөнгүүд хатуу ширүүн өвлийн улиралд эсэн мэнд үлдэх хангалттай, баталгаатай идэш тэжээлийн нөөцтэй байхад туслах болно.



Зургаа: Гүндэнсамбуугийн Гунбат

Бөхөн ажиглагдсан цэгүүдэд сонгон авсан талбайд ургамлын судалгааг гүйцэтгэж байгаа нь

Редакторын тэмдэглэл: Уг судалгааг Гүндэнсамбуугийн Гунбат, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний тэтгэлэгт Баярбаатарын Бүүвэйбаатар нар Бөхөн хамгаалах нийгэмлэгийн элжжиг тэтгэлгээг зүйлэтгэсэн юм


Бөхөнгийн нүүдлийн судалгааг хийх ирээдүйн арга зам

Самуел Кавенаг

Лондонгийн Эзэн хааны коллеж, samuel.cavenagh08@imperial.ac.uk

Амьтны нүүдлийн судалгааг хийх арга дэлхий нийтээр өөрчлөгдөж байгаа бөгөөд энэ нь бөхөнгийн нүүдлийн судалгаатай мөн хамааралтай. Сансрын дохиололтой хүзүүвч зэрэг орчин үеийн дэвшилтэт технологи нь тухайн амьтны томоохон сүргээс илүүтэйгээр бодгаль амьтны шилжилт хөдөлгөөнийг судлах боломжийг судлаачдад олгож байна. Жишээлбэл, өнөө үед бөхөнгийн нүүдлийн шалтгааныг тодруулах судалгаа нь улирлын байдлаар ургамлын гарц их болон бага болон өөрчлөгддөг өөр газар нутаг, бөхөнгийн томоохон сүргийн хоорондох уялдаа холбоог ажиглах замаар хийгдэж байна. Одоогоор бөхөнд сансрын дохиололтой хүзүүвч зүүж байгаа нь (*Бөхөнгийн мэдээ-10, 12-ыг хар*) бодгаль амьтан өөрсдийн нүүдлийн замыг хэрхэн, яаж сонгодог болохыг шалган, илүү их нарийвчлалтай тодорхойлдог учраас бодгаль амьтны түвшинд ажиллах боломжтой юм.

Өнөө үед нүүдлийн судалгааг янз бүрийн мэргэжлийн салбар оролцон илүү олон талт арга замаар хийж байна. Одоо уг судалгааг хийхдээ генетик, физиологийн үйл явц, гадаад нөхцөл, тэдгээрийн хоорондох уялдаа холбоо, эдгээр хүчин зүйлүүд амьтны шилжилт хөдөлгөөний хэв маягт хэрхэн нөлөөлөх зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж байна.



Диаграмм 1.

Натан нарын 2008 онд боловсруулсан амьтны шилжилт хөдөлгөөнийг судлах бүдүүвч.


Дотоод нөхцөл (яагаад нүүх болов?), Явах орон зайн багтаамж (хаашаа нүүх вэ?), Хөдөлгөөний хүчин чадал (яаж нүүх вэ?) болон гадаад хүчин зүйлүүд нь бие биетэйгээ уялдан холбогдож тухайн организмын нүүдлийн хэв маягт нөлөөлдөг.

Натан нар (2008) ажлын дүнд нүүдлийн судалгааг хийх шинэ салбар дундын үзэл баримтлалыг боловсруулан гаргасан (Диаграмм. 1).

Энэхүү шинэ судалгааны үзэл баримтлалын дагуу нүүдлийн судалгаанд зөвхөн амьтны байршлын мэдээлэл төдийгүй тухайн амьтны зан төрхийн мэдээлэл, тэдгээрийн эрүүл мэндийн байдал (жин гэх мэт), хүрээлэн буй орчны хувьсан өөрчлөгддөг олон хүчин зүйлийн мэдээлэл шаардагдана. Шилжилт хөдөлгөөний сонголт нь хүрээлэн буй орчныг мэдрэх амьтны мэдрэхүй зэрэг амьтанд үүсэн бий болсон хүчин зүйлүүдээр тодорхойлогддог болох нь энэхүү доороос дээших арга замууд харуулж байна.

Амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөний илүү сайн хэмжүүрийг (цаг хугацаа ба орон зайн хувьд) бий болгох зорилгоор амьдрах хугацаан дахь шилжилт, шилжилтийн үе, шилжилтийн алхам гэсэн гурван өөр хэмжээсийг ялгаж болно (Диаграмм 2). Шилжилтийн алхам нь сансрын дохиололтой хүзүүвчнээс хүлээн авсан байршлын мэдээллийн хоёр дараалсан цэг бөгөөд энэ нь шилжилт хөдөлгөөний мэдээллийг задлан шинжлэхэд хамгийн сайн хэмжүүр болдог. Шилжилтийн үе нь тодорхой зорилгыг биелүүлэх үед (махчдаас зугтах, илүү сайн бэлчээрт хүрэх) зан төрхийн онцлогоор илрэн гарах хэд хэдэн шилжилтийн алхамаас бүрдэнэ. Шилжилтийн үе нь уламжлалт ажиглалтын судалгааг бодгаль амьтан дээр суурилсан шинэ арга зүйг холбон бодитоор тодорхойлогдох болно. Задлан шинжлэх шинэ арга болох “шилжилт хөдөлгөөний торлол” (NSD) нь шилжилт хөдөлгөөний зай, хугацаа, явцын ялгааг статистикийн тооцооллоор шалган, харилцан адилгүй шилжилтийн үеүдийг танин мэдэхэд ашиглагддаг.

Шилжилт хөдөлгөөний судалгааны шинэ арга зүй нь бөхөнгийн судалгаанд олон тооны боломжийг бий болгож байна. Жишээлбэл, бодгаль амьтан тэдгээрийн нүүдлийн хэв маягт ямар хэмжээгээр дасан зохицож байна вэ? Энэ асуултын хариулт нь хүрээлэн буй орчны байгаль цаг уур болон бусад өөрчлөлтийг даван гарах бөхөнгийн чадвараас маш их шалтгаалах байх бөгөөд эндээс тэдгээрийн хамгааллыг төлөвлөх чухал шийдвэрүүд гарах болно. Тэдгээрийн хүрээлэн буй орчны өөрчлөлт, нүүдэл шилжилт хөдөлгөөнд дасан зохицох бодгаль амьтны чадвар нь тэдгээрийн нүүдэлд нөлөөлөх механизмаас хамааралтай томоохон хэсэг байх болно. Жишээлбэл, энэ ямар нэгэн ой тогтоолт уу (генетикийн үүднээс тодорхойлох боломжтой), эсвэл бодгалиуд хүрээлэн буй орчноос ирсэн дохионд шууд хариу үйлдэл үзүүлж байна уу?, мөн шилжин нүүдэллэх хамгийн сайн замыг хэрхэн сонгодог вэ? Бөхөнгийн шилжилт, хөдөлгөөний хандлага генетикийн үүднээс үндсэндээ тогтоогдсон. Амьтны хүрээлэнд буй бөхөнгийн янзаганд нүүдэллэх зан авир маш хүчтэй илэрдэг. Бөхөнгийн нүүдлийн чиглэлийг генетикийн үүднээс авч үзвэл үндсэндээ тодорхой бус байна. Сансрын дохиололтой хүзүүвчийг ашиглан бодгаль бөхөнгийн шилжилт хөдөлгөөнийг олон жилийн давтамжтайгаар судлах нь энэ асуултанд хариулахад тусалж магадгүй юм. Хэрвээ бодгаль амьтдын нүүдлийн замыг олон жилийн давтамжтай судлахад бодитой ялгаа илэрч байвал үүнийг хөдлөшгүй генетикийн нотолгоогоор болон тэдгээрийн нүүдлийн чиглэлийг хянах зөн билэгт суурилсан тайлбарууд учир дутагдалтай болох бөгөөд харин эсрэгээр бөхөн өөрсдийн нүүдлийн замыг тодорхойлоход хүрээлэн буй орчны дохиог ашигладаг болохыг харуулна.



Диаграмм 2.

Бодгаль бөхөнгийн жилийн шилжилт хөдөлгөөний таамаглал (1. Эхний жилийн шилжилтийн хэв маяг, 2. Хоёр дахь жилийн шилжилтийн хэв маяг, 3. Гуравдахь жилийн шилжилт хөдөлгөөний хэв маяг).

Дунд талын зурагт шилжилтийн үеийг харуулсан (идээшлэх үе). Дээд талын зурагт шилжилтийн үе доторхи шилжилт хөдөлгөөний хамгийн сайн хэмжүүрийг харуулсан (шилжилтийн алхам).

Ф. Идээшлэх үе, М. Нүүдлийн үе, С. Төллөх үе.

Бие биеэс ялгаатай бөхөнгийн бодгалийн шилжилт хөдөлгөөний хэв маяг өөр хоорондоо хир ялгаатай байдаг нь одоогоор тодорхойгүй байна. Хандгай зэрэг бусад зүйлүүдийн нүүдлийн хэв маягт хүйс, нас, давамгайлал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг болох нь нотлогдсон. Шилжилт хөдөлгөөний торлолын аргыг ашиглан анализ хийсэн газарзүйн байршлын мэдээлэл нь бөхөнгийн популяцийн аливаа ялгааг тодруулах үндэс болон ашиглагдаж болох юм. Тухайн анализыг гүйцэтгэх нь зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгаас шахагдсан популяцийн (өөрөөр хэлбэл эр амьтан) тодорхой бүрдэл хэсэгт ашиглагдаж буй газар нутаг дахь популяцийн түвшний хэв маягийг харгалзан үздэг учраас хамгаалалд чухал ач холбогдолтой.

Бодгалийн ялгааг харгалзан үзсэн шилжилт хөдөлгөөний загварчлалыг байгаль цаг уурын болоод хүрээлэн буй орчны бусад өөрчлөлттэй тулгарах үед бөхөнгийн нүүдлийн загварчлалыг бодитойгоор гаргахад ашиглаж болох юм. Эдгээр анализ нь ирээдүйн хүрээлэн буй орчны төлөвлөлтөнд ашиглагдана (уур амьсгалын өөрчлөлтийн байдлыг засгийн газар хоорондын хэлэлцээрээр шийдсэн шиг). Бодгаль амьтан дээр суурилсан шилжилт хөдөлгөөний загварчлал нь бидний олж авсан мэдлэг дээр суурилан зайлшгүй хамгаалах ёстой газар нутаг, цаашид хүрээлэн буй орчны хамгааллыг төлөвлөхөд ашиглагдана.

Узбекистанд хэрэгжиж буй мониторинг аргачлалын

ҮНЭЛГЭЭ

Сюзанне Оффорд

Лондонгийн Эзэн хааны коллеж, suzanne.offord10@imperial.ac.uk

ЗАНЗХК-ийн олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийн эн тэргүүний үйл ажиллагаа нь Устюртын бөхөнгийн популяцийн улирлын тархцын тухай үндсэн мэдээллийг бүрдүүлэх явдал юм. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд Узбекистаны бөхөнгийн мониторинг судалгааны үйл ажиллагаа олон бэрхшээлээс үүдэн бараг хязгаарлагдсан байна. Илүү үр дүнтэй, алдаа мадаггүй замаар мониторинг судалгааг хийх нь уг судалгааг үнэ цэнэтэй болгоход чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч суурь судалгаанд үүнийг ашиглахгүйгээр илүү үр дүнтэй байж чадах ямар арга зүйг хэрэглэх нь маш хэцүү юм. Миний бие хамтран ажиллагсадын хамт суурь судалгааг хөгжүүлэх зорилгоор бөхөнгийн мониторинг хийх арга зүйг үнэлэхийн тулд 2011 оны 6 сард Узбекистанд ажилласан.

Би дэлхий дахинд уулын туруутны судалгаанд ашигладаг мониторинг судалгааны бүх арга зүйг, мөн

бөхөнгийн популяцийг үнэлэхэд урьд өмнө болоод одоо ашиглагдаж байгаа арга зүйг үнэлсэн. Орон нутгийн хүмүүсийн гүйцэтгэсэн байгаль цаг уур, тохиолдсон зүйлс, түүнчлэн мониторинг судалгааны талаарх мэдээллийг цуглуулсан. Уг загварчлал нь тухайн аргачлал бүрийн үр бүтээмжийг үнэлэх, цуглуулагдсан мэдээлэл үнэн зөв эсэхийг үнэлэхэд ашиглагдсан. Уг судалгаагаар дараах зүйлүүдийг тодорхойлсон:

1. Мониторинг мэдээллийг бодитойгоор үнэлэх чадварыг дээшлүүлэх. Distance sampling нь илүү үнэмшилтэй мэдээллийг бэлтгэж чадна.
2. Машин болон мотоцикл нь хамгийн үр бүтээмжтэй хэрэгсэл бөгөөд ашиглахад тохиромжтой юм.
3. Мөр болон баасаар тоолохоос илүүтэйгээр бөхөнг тоолох нь үр дүнг илүү өндөр нарийвчлалтай гаргах болно.
4. Мониторинг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа судлаачдын цалин хөлс нь үндсэндээ өндөр өртөгтэй байсан бөгөөд энэ нь тухайн арга зүйн бүтээмж өндөр байхад нөлөөлнө.

Бөхөнг тоолохдоо Distance sampling программыг ашиглан трансектын дагуу мотоциклоор явж байгаа орон нутгийн судлаачдын оролцсон мониторинг арга зүй нь бодитой, илүү үр бүтээмжтэй байдаг болохыг судалгааны дүн харуулж байна. Энэ арга зүйн дагуу Елена Быковад олгосон Витлейн шагналаар хэрэгжүүлсэн судалгааг одоогоор туршилтын журмаар хэрэгжүүлж байна. Энэ туршилтын төслийн үр дүнг 2012 оны сүүлээр харна гэдэгтэй бид итгэлтэй байна. Хэрвээ та бүхэнд энэ ажлын дэлгэрэнгүй тайлангийн хуулбар хэрэгтэй бол Елена Быкова миний бие, (esipov@xnet.uz) эсвэл Е.Ж. Милнер-Гулланд (e.j.milner-gulland@imperial.ac.uk) нартай холбогдоно уу. Энэ тайлан англи хэл дээр хэвлэгдсэн бөгөөд тун удахгүй орос хэл хөрвүүлэгдэн гарах болно.



Зургийг Александр Есипов

Сюзанне Оффорд болон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн багийнхан хоньчны фермд

Уралын бөхөнгийн популяцид тохиолдсон их хэмжээний үхэл хорогдлын дараа уг популяцийг хамгаалахад олон нийтийн оролцоог бий болгох нь

Карлын Самуел, Ольга Климанова, Мирбулат Урымбаев, Е.Ж. Милнер-Гулланд

Сурвалжсан бичсэн: Карлын Самуел, Лондонгийн эзэн хааны коллеж, carlynsamuel@o2.co.uk

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн “Уралын бөхөнгийн популяцид тохиолдсон их хэмжээний үхлийн дараах уг популяцийг хамгаалалд олон нийтийн оролцоог бий болгох” гэсэн төсөл “Өөрсдийн зүйлээ хамгаалцгаая” хөтөлбөр, Ховордсон амьтдыг хамгаалах хүмүүсийн сан, Диснейн зэрлэг амьтан хамгаалах сан зэрэг байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2010 оны 8 сараас хэрэгжиж эхлэсэн. 2010 оны 5 сард Уралд бөхөн их хэмжээгээр үхсэн асуултанд хариу өгөхөөр хэрэгжиж буй уг төслийн (энэ талаарх өгүүллийг Бөхөнгийн мэдээ 11-ээс хар) бүс нутгийн хамтрагчаар Бөхөн хамгаалах нийгэмлэг, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг ажиллаж, Лондоны эзэн хааны коллежтай хамтран хэрэгжүүлж байна.

Уг төсөл нь бөхөнгийн тархац нутаг дахь 7 үндсэн тосгоны оршин суугчид, хүүхдүүд рүү чиглэсэн хүрээлэн буй орчны болон боловсролын кампанит ажлыг хэрэгжүүлэхэд оролцдог.

Энэхүү кампанит ажил нь бөхөнгийн тухай, мөн хулгайн ан, өвчин эмгэг зэрэг бөхөнгийн популяцид учирч буй бэрхшээлүүдийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байсан. Ерөнхий зорилго нь бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхээр ажиллаж буй урт хугацааны оролцооны хөтөлбөрийн үндэс суурийг бэлтгэхийн тулд бөхөн рүү хандах хүмүүсийн хандлага, тэдний үзэл бодлыг дэмжихэд оршиж байсан.

КБТЗХН-хэн кампанит ажил эхлэхийн өмнө буюу 2010 оны 1 сард бүх тосгонуудаар айлчлан, бөхөнд хандаж буй тэдний хандлага, бөхөнгийн талаарх бодит мэдлэгийг үнэлэхийн тулд тосгоны оршин суугчдаас асуулга судалгаа авсан. Тус нийгэмлэгийнхэн тосгон бүрт мэдээллийн өдөрлөг, сургууль бүрт боловсролын өдөрлөгийг зохион байгуулсан. Бөхөнгийн өдрийг тосгон бүрт зохион байгуулах үед энэ кампанит ажил оргил үедээ хүрсэн бөгөөд уг үйл ажиллагаанд тосгоны оршин суугчид, тэдний хүүхдүүд идэвхтэй оролцож, эерэгээр хүлээн авсан (бөхөнгийн мэдээ 12-ын хар).

Уг төслийн шатанд буюу 2011 оны 6 сард орон нутгийн оршин суугчид болон хүүхдүүд нийлсэн 400 гаруй хүнээс уг төслийн үр дүнг үнэлэх зорилгоор судалгаа авсан. Энэ судалгаанаас гарсан үр дүнг өмнөх судалгаатай харьцуулж уг кампанит ажлыг гүйцэтгэснээр орон нутгийн хүмүүсийн мэдлэгийн түвшин, бөхөнд хандах тэдний хандлага, үзэл бодол хэрхэн өөрчлөгдсөнийг, мөн кампанит ажлын амжилтыг харуулж буй томоохон өөрчлөлтийг олж үнэлэхэд тусалсан. Нэмж хэлэхэд, “гадаад” хамгааллын арга хэмжээ болоод үйл явцыг орон нутгийн хүмүүс хэрхэн үнэлсэн, энэ нь тэдний амьдралд ямар нөлөө үзүүлсэн зэрэг судалгааны үр дүн нь улам их итгэл найдвар төрүүлсэн. Бөхөн хамгаалалд орон нутгийн хүмүүсийн гүйцэтгэх үүргийг эерэг, өөдрөг талаас нь ойлгуулж, бөхөн хамгаалал руу чиглэсэн хүмүүсийн сайхан сэтгэл, мэдрэмжийг бий болгосон амжилтаар арвин кампанит ажил болсныг судалгааны үр дүнд онцолсон. Кампанит ажлын дараа судалгаанд хамрагдсан хүмүүсийн мэдлэгийн түвшин уг ажил эхлэхийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад хамаагүй өндөр байсан нь энэ ажлын дүнд орон нутгийн бүх хүмүүст бөхөнгийн талаар маш сайн мэдлэгтэй болсныг харуулж байна. Орон нутгийн хүмүүс өөрсдөдөө хэрэгцээтэй байгаа бөхөнгийн тухай бүх мэдээллийг олж авсан гэж хариулсан хүмүүсийн тоо уг кампанит ажил эхлэхийн өмнө хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад даруй 38%-иар нэмэгдсэн байна. Судалгаанд оролцогсдын 93% нь кампанит ажлын үед өөрсдөд нь маш чухал хэрэгцээтэй мэдээллийг олгосон гэж бодож байгаа бөгөөд уг судалгаанд оролцсон нэгэн хүн “Тун удалгүй бөхөнгүүд бүгдээрээ арслан заантай устаж алга болох байсан” гэж бичсэн байна.

Сонирхолтой нь гаднаас ирсэн хүмүүс тосгонд кампанит ажлыг зохион байгуулсан учраас илүү чухал мэдээллийг хүмүүст өгсөн. Гаднаас ирсэн хүмүүс кампанит ажлыг зохион байгуулснаар зарим хүмүүс илүү их зүйлийг ойлгож мэдрэн, “Өмнө нь бидэн рүү хэн ч ирдэггүй байсан, бид бөхөнд тулгарч байгаа асуудлуудыг мэддэггүй байсан. Хэрвээ байдал энэ хэвээр үргэлжилсээр байсан бол манай хүүхдүүд бөхөнг хэзээ ч харахгүй байсан. Харин одоо тэд бөхөнг хамгаалахын ач тусыг ойлгож байна” гэж бичжээ.

Нэгэн оролцогч Казахстаны бөхөнгийн хувь тавилан ээдрээтэй байгаа бөгөөд энэ асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулахад сурталчилгааны кампанит ажил эерэг нөлөө үзүүлсээр байгааг дурдаад, “Бөхөн устан алга болж байгаа нь биднийг хүрээлэн буй орчинд ан амьтанд тулгарч буй нийтлэг асуудал болохыг ойлгоход энэхүү сурталчилгааны кампанит ажил бидэнд тусалж байна; Бидний олонх нь энэ нутагт байнга амьдарсаар ирсэн боловч бөхөнгийн тухай хэзээ ч сонсож байгаагүй. Харин одоо бөхөнгийн тухай хүн бүр, цаг үргэлж ярьж байна” гэж бичсэн байна. Зарим оролцогчид кампанит ажил нь хүүхдэд бага наснаас нь эхлэн байгаль ба зэрлэг амьтныг хайрлан хамгаалах, хүндэтгэхийг зааж сургаснаараа маш чухал ач холбогдолтой болсон гэж үзсэн байна.



Зургийг Карлын Самуел

Энэ бяцхан охин Бөхөнгийн өдөрт маш идэвхтэй оролцож байсан.

Зарим оролцогчид уг кампанит ажлын үйл ажиллагаа тэдний өөрсдийнх нь тосгонд үнэгүй болсныг талархан хүлээн авсан бөгөөд уг ажлаас олж авсан өөрсдийн туршлага мэдлэгээ эерэгээр үнэлсэн.

Кампанит ажил эхлэснээс хойш бөхөн хамгаалал руу чиглэсэн хүмүүсийн хандлага эрчимтэйгээр нэмэгдсэн.

Кампанит ажил эхлэхээс өмнө ихэнх хүмүүс бөхөн устаж магадгүй болсон тодорхой үед л санаа зовнино гэж хариулсан бол зарим нэг нь бөхөн устахад огт санаа зовохогүй гэж хариулсан байна. Харин кампанит ажил хийгдэж дууссаны дараа бараг бүх хүмүүс “Бөхөн устаж магадгүй гэдэгт маш их санаа зовниж байна” гэж хүлээн зөвшөөрсөн.

Сурталчилгааны кампанит ажил нь орон нутгийн хүмүүсийн бөхөн рүү чиглэсэн эерэг хандлагыг нэмэгдүүлэхэд тусалсан бөгөөд Уралын бүс нутагт амьдарч буй орон нутгийн иргэд бөхөн хамгаалалд оролцох болно гэдгийг энэ төсөл батлан харуулсан.

Уг ажлын дараагийн алхам нь сургуулийн сургалтын календарчилсан хөтөлбөрт хүрээлэн буй орчны боловсрол, бөхөнгийн сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулахаар тусган, бүс нутагт бөхөн хамгааллын үйл ажиллагааг дэмжигч багийг үүсгэн байгуулах зэрэг зорилготой байгаа болно. Уг төслийг улам бүр өргөжүүлэн үргэлжлүүлснээр маш хүчирхэг эерэг мэдрэмжийг бий болгох бөгөөд зөвхөн гаднаас ирсэн хүмүүс бус, орон нутгийн иргэд өөрсдөө бөхөн хамгаалахад хувь нэмрээ оруулах боломжтой гэдгийг тэд мэдэрч байна.



Зургийг Карлын Самуел

Карлын Самуел орон нутгийн оршин суугчид болон КБТЗХН-ийн сайн дурынхан, оюутнуудын хамт

ОХУ-ын бөхөн хамгаалах үндэсний төлөвлөгөөг хөгжүүлэх нь

Ольга Переладова

ДБХС-ийн Орос дахь Төв Азийн хөтөлбөрийн газар, opereladova@wwf.ru

Боннд болсон уулзалтын явцад буюу 2009 оны 6 сард ЗАНЗХК-ийн харилцан ойлголцлын санамж бичигт тус улс гарын үсэг зурснаар хүлээсэн үүргийн нэг хэсэг нь бөхөн хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх явдал нь ОХУ-ын эн тэргүүний зорилтуудын нэг юм. Энэ ховордсон зүйлийг хамгаалах үндэсний төлөвлөгөөг засварлан сайжруулах хэрэгтэй. Энэ хөтөлбөрийг сайжруулан, цаашид хэрэгжүүлэх нь ОХУ-д, ялангуяа бөхөнгийн тоо толгой харамсалтайгаар үргэлжлэн буурсаар байгаа баруун хойд пре-Каспийн (Халимаг, Астраханд болон хил зэргэлдээ нутагт) бүс нутагт зайлшгүй хэрэгтэй. Тус нутагт 2000 оны эхээр 18-20000 бөхөн байснаа одоогийн байдлаар 7000 орчим болтлоо буурсан (энэ тухай өгүүллийг Бөхөнгийн мэдээ 13-аас хар). Энэ хооронд, ижил хугацаанд, ижил байгаль цаг уурын нөхцөл дэхь ургамлан нөмрөгийн ижил хэв маягт оршиж байгаа Казахстаны бөхөнгийн нийт тоо толгой 20000-аас 100000 гаруй болтлоо өссөн бол, 2002-2003 онд 3-4000 толгойгоор үнэлэгдэж байсан Бетпакдалагийн бөхөнгийн тоо толгой 2011 онд 70000 гаруй болж өссөн байна. Казахстаны БНУ-ын жишээ нь уг зүйлийг нөхөн сэргээх нь бүрэн боломжтой болохыг харуулна.

ДБХС-ийн Орос дахь хөтөлбөрийн газар 2010 оны намар 2011-2015 он хүртэлх хугацаанд бөхөн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний засварыг ОХУ-ын хүлээсэн үүргийг бүрэн дүүрэн биелүүлэх ажилтай уялдуулан хийж эхлэсэн. Судлаач, байгууллага болон тохиромжтой бүс нутгийн төрийн байгууллагуудын өргөн хүрээтэй хэлэлцүүлгийн үр дүнд эхний хувилбар батлагдаж, бүх тайлбар, нэмэлт өөрчлөлт, засваруудыг хийсэн.

Энэхүү төлөвлөгөөний хувилбарт бөхөн хамгаалахын тулд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээний багц, зохицуулах механизм, уг зүйлийг

хамгаалах, нөхөн сэргээх хууль эрх зүйн орчин зэрэг хамрагдсан. Хамгийн чухал нь уг зүйлийн нүүдлийн замыг хамгаалах зорилгоор ТХГН-ийн сүлжээг сайжруулах, ТХГН-ийн гадна талд байгаа бөхөнгийн хамгааллыг нэмэгдүүлэх, зүйлийн амьдрах орчны нөхцлийг дээшлүүлэхийн тулд багц арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний бусад хэсгүүдэд тодорхой чиглэл бүхий шинжлэх ухааны суурь судалгааг хөгжүүлэх, түүнчлэн популяцийн ялангуяа популяцид сөрөг нөлөө үзүүлэхгүй арга зүйг ашиглан бөхөн болон тэдгээрийн амьдрах орчны мониторинг судалгааг өргөжүүлэх асуудлыг багтаасан. Уг үйл ажиллагааны хөтөлбөрт Оросын бөхөнгийн популяцийг хамгаалахад орон нутгийн бүлэг, нөхөрлөлийг оролцуулахад чиглэгдсэн янз бүрийн хөтөлбөр, боловсролын үйл ажиллагаануудыг оруулсан.

Уг үйл ажиллагааны төлөвлөгөө 2011 оны 10 сарын 31-нд Ховордсон зүйлүүдийг хамгаалах комиссын хурлаар батлагдсан бөгөөд тогтоосон журмын дагуу эцсийн байдлаар дуусгаж, албан ёсоор батлан хэрэгжүүлэх зорилгоор ОХУ-ын Байгалийн Нөөц, Экологийн яаманд хүргэгдсэн болно.



Зургийг Надежда Арылова

Халимагын БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвд байгаа бөхөнгүүд

Бөхөнгийн баатрууд

Редакторын тэмдэглэл: Энэ дугаарт бид Узбекистаны БНУ-ын Байгаль хамгаалах хорооны улсын биохианалтын хэлтсийн дарга Александр А.ГРИГОРЯНЦ-тай манай сэтгүүлчийн хийсэн ярилцлагыг нийтэлж байна. Ноён ГРИГОРЯНЦ Узбекистаны цоры ганц байгалийн өвийг хамгаалахаар олон жилийн турш ажиллаж байна. Түүний ажлын хамгийн дурсгалтай мөч нь хулгайн антай тэмцэх шуурхай бүлэгтэй амьдралаа холбосон явдал юм. Тэрээр бөхөн хамгааллын үйл ажилагааг хангадаг ЗАХЗОУХХК, ЗАНЗХК зэрэг олон улсын конвенцийн хэрэгжилтийг хангахад анхаарал хандуудан ажиллаж байна.

Редактор: Та анх хэзээнээс эхэлж бөхөнг сонирхож эхэлсэн бэ?

А.Г.: Би хүүхэд байх үеэсээ л зэрлэг амьтдын амьдралыг маш их сонирхдог байсан. Зурган дээрээс анх удаа бөхөнг хараад (хэзээ байсныг би сайн санадаггүй) түүний ер бусын гадаад төрх намайг алмайруулсан. Гэвч энэ зүйлийг сонирхох миний сонирхол 1976 онд намайг Мэргэжлийн хяналтын газарт ажилд орсон үеэс эхлэсэн.

Редактор: Таны ажлын өдөр хэрхэн өнгөрдөг вэ?

А.Г.: Сүүлийн үед би захиргааны болоод бичиг цаасны маш их ажилтай байна. Янз бүрийн асуудлыг хэлэлцэхээр манай байгууллага дээр ирсэн олон хүмүүстэй тогтмол уулздаг. Хэрвээ манай ажилчид өөрсдийн түвшинд тэдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол шийдвэр гаргахад би оролцдог. Хамгийн харамсалтай нь одоогоор би хяналт шалгалтын ажлыг маш бага хэмжээнд хийж байна.

Редактор: Бөхөнгийн тухай ямар нэгэн сонирхолтой түүхийг бидэнд ярьж өгч болох уу?

А.Г.: Би хяналт шалгалтын ажилд оролцож явахдаа бөхөнтэй байнга тааралддаг байсан. Хэдийгээр ингэж явахад олон янзын нөхцөл байдалтай нүүр тулгардаг байсан боловч энэ нь ердөө миний ажил байсан учраас үүийг би ямар нэгэн гайхалтай зүйл мэтээр хүлээж авдаггүй байсан.

Редактор: Таны ажлын үндсэн асуудлууд юу байдаг вэ?

А.Г.: Гол асуудал нь байцаагчдын техник тоног төхөөрөмж, боловсон хүчний сургалт, байгалийн нөөцийн ашиглалтын хяналтыг чангатгахтай холбоотой засвар, нэмэлт өөрчлөлтүүд зэрэг орно.

Редактор: Таны ажилд тулгарч буй бэрхшээлүүдийг хэрхэн даван туулж чадах вэ?

А.Г.: Хамгааллын тухай сурталчилгааны ажлыг шийдвэр гаргагчдын дунд хөгжүүлэх ёстой. Нэмж хэлэхэд, бид тэдэнд хамгааллын тухай сургах ёстой. Ирээдүйд байгаль орчныг нөхөн сэргээхэд тэрбум доллар зарцуулж байснаас өнөөдөр байгаль хамгаалахад сая доллар зарцуулах нь хамгийн хялбар, хамгийн сайн арга зам болохыг улс төрчид, эдийн засагчид ойлгох ёстой.

Редактор: Таны ажлын хамгийн сайхан зүйл юу вэ?

А.Г.: Өөрийн ажлаас баяр хөөрийг мэдэрч байдаг,

байгаль хамгааллын ажлыг үр өгөөжтэй болгохын тулд өөрийн хүчээр хийж чадах бүх зүйлийг хийж байгаа нь миний ажлын хамгийн сайхан зүйл юм.

Редактор: Бөхөн хамгааллын хэтийн төлөв байдал юу вэ? Энэ зүйлийг эсэн мэнд авч үлдэхийн тулд хамгийн түрүүнд ямар зүйлийг хийх шаардлагатай вэ?

А.Г.: Олон жилийн өмнө бөхөн бүрмөсөн устаж алга болохын даваан дээр байсан боловч хатуу чанга хуулиуд нь түүнийг нөхөн сэргэхэд тусалсан. Бид хамгаалал, хууль эрх зүйн орчныг хүчирхэгжүүлэх, орон нутгийн хүмүүсийн дунд сурталчилгааны ажил сайтар хийх, хуулийн шаардлагад үг дуугүй захирагдах зэрэг асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Бид бөхөнгийн тоог нөхөн сэргээж чадна гэдэгт би бат итгэлтэй байна.

Редактор: Та олон жилийн турш бөхөнг хамгаалахаар ажиллаж байна. Эдгээр жилүүдэд юу өөрчлөгдсөн бэ? Дэлхийн өнөөгийн хандлага юу байна вэ?

А.Г.: Гиймээ, Би урт удаан хугацаанд энэ салбарт ажиллаж байгаагийн хувьд сайн сайхан зүйл рүү чиглэсэн хандлага ажиглагдаж эхэлж байгаа гэж хэлж чадна. Хамгааллын үйл ажиллагаа нь зарим нэгэн хэт улайрагчдын хийрхэл биш, харин бидэнтэй холбоотой эх дэлхий, ертөнцийн амьдралыг хамгаалахад зайлшгүй чухал хэрэгцээтэй гэдгийг илүү олон хүмүүс ойлгож эхэлж байна. Байгальд хил хязгаар байдаггүй болохыг олон хүмүүс, тэр тусмаа улс төрчид ухамсарлаж эхэлж байна. Энэ нь ойрын ирээдүйд байгаль хамгааллыг чухал ач холбогдолтой дэвшилд хөглөх болно гэдэгт би итгэлтэй байна.



Зургаа Александр Григорянц

Александр Григорянц өөрийн өрөөндөө.

Үргэлжилж буй төслүүд



2011 оны БХН-ийн жижиг тэтгэлгийн шалгаруулалт

Бид 2011 онд 2 бие даасан жижиг тэтгэлгийн шалгаруулалтыг зарласан. Ан амьтдыг хамгаалах зөвлөл (СIC), Зэрлэг амьтдын хамгаалах сүлжээнээс санхүүжүүлсэн эхний сонгон шалгаруулалт нь үндсэн төслүүдийг дэмжихээр явуулж буй бидний үйл ажиллагааг үргэлжлүүлэх, ЗАНЗХК-ийн бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичгийн дунд хугацааны ажлын хөтөлбөрт тусгагдсан эн тэргүүний ажлуудыг хэрэгжүүлэх, эдгээр ажлуудын чадавхийг нэмэгдүүлэх зорилготой байсан. Тэтгэлэг хүлээн авагчдыг Бөхөн хамгаалах нийгэмлэгийн удирдах зөвлөлийн хурлаар 2011 оны 9 сард шалгаруулсан. Энэ жил бид газарзүйн байршил, үйл ажиллагааны хувьд өргөн хүрээнд хэрэгжих маш сайн 3 төслийг дэмжин хэрэгжүүлэхээр болсондоо таатай байна. Эдгээрт:

- Мингкса Занг (Хятад) “Хятадын Гуаньжоу дахь бөхөнгийн эврийн хууль бус худалдааг багасгах нь”
- Максут Заримбетов (Казахстан) “Бөхөнгийн түүх комикс номыг бүтээх, хувилах, түгээх”
- Виктория Ностаева (ОХУ) “Халимагийн БНУ-ын сургуулийн хүүхдүүдийн экологийн боловсролд зориулан лекц болон бөхөнгийн тухай өргөн хүрээтэй хөдөлгөөнт дэлгэц бүхий мэдээллийг бэлтгэх”

Бөхөн хамгаалах нийгэмлэг өмнөх сонгон

шалгаруулалтанд орсон боловч тэнцээгүй үлдсэн хүмүүст зориулан дахин нэг сонгон шалгаруулалт явуулахад туслалцаа үзүүлэхийг АНУ-ын Загас ба Зэрлэг амьтан судлалын холбооноос хүссэн. Энэ нь жил бүр Бөхөн хамгаалах нийгэмлэгээс зохион байгуулдаг шалгаруулалттай ижил боловч 2000\$-оос дээш 20000\$ хүртэлх төсөвтэй төслүүдээс шалгаруулалтаа хийсэн. Олон улсын, бие биетэйгээ хамааралгүй 7 судлаач хамгийн сайн төслийг сонгон шалгаруулах зөвлөлд орсон. Бид 3 өөр улсад хэрэгжих, нэн тэргүүний шаадлагатай үйл ажиллагааг явуулахаар төлөвлөсөн хамгийн сайн 4 төслийг дэмжихээр болсондоо баяртай байна:

- Анатолий Клюднев (ОХУ) “Астраханы бүс нутгийн бөхөн хамгааллыг сайжруулах, хулгайн ангийн эсрэг үр дүнтэй тэмцэхэд “Степной” дархан газрын техник, тоног төхөөрөмжийн нөхцлийг нэмэгдүүлэх”.
- Юрий Арылов (ОХУ) “Орон нутгийн хүмүүсийн ажиглалт, мэдээллийг ашиглан баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн мониторинг хийх”.
- Батхуяг Балдангомбо (Монгол) “Монголын баруун хэсэг болон Хятад дахь бөхөнгийн дайвар бүтээгдэхүүний хил дамнанас худалдаанаас урьдчилан сэргийлэх чадавхийг нэмэгдүүлэх”.
- Ян Ксие (Хятад) “Хятадын Гуаньжоу дахь бөхөнгийн эврийн хууль бус худалдааг багасгахад засгийн газраас гаргасан хуулийн хэрэгжилтийн чадавхийг нэмэгдүүлэх”.

Бид долоон ялагчидаа баяр хүргэхийн ялдамд Бөхөнгийн мэдээ-ний цаашдын дугааруудаас тэдний ажлын тухай уншихыг тэсэн ядан хүлээж байна.



Зарлал

ЗАНЗХК-ийн олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийн зохицуулалт



Бөхөн хамгаалах нийгэмлэг (БХН), Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХК) хоёр бөхөн хамгаалал дээр хэрэгжих Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийг (ОУДХАХ)-ыг

зохицуулахын тулд 2011 оны 2 сард болсон Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн (ЗАНЗХК) хурлаар гарын үсэг зурсан. ЗАНЗХК, КБТЗХН, БХН-ийн жижиг тэтгэлгийн санхүүжилтэйгээр бөхөн хамгаалах төсөл, судлаачдын мэдээллийн сан үүсгэх (КБТЗХН-ийн удирдлаган), Бөхөнгийн нөөцийн төвийг (SRC) онлайн хэлбэрээр үүсгэх (БХН-ийн удирдлаган дор) гэсэн хоёр үндсэн чиглэлээр ажиллаж байна. Энэ хоёр мэдээллийн санг хооронд нь нэгтгэх бөгөөд онлайн хэлбэртэй мэдээллийн сангаас шүүлт хийх, нэмж сайжруулах бүрэн боломжтой юм. Үүнийг зөвхөн бүртгэлтэй хэрэглэгч нар хийх боломжтой.


Бөхөнгийн нөөцийн төв вебсайт нь олон нийтэд зориулагдсан бөгөөд хүссэн хүн бүр бөхөнгийн тухай зураг, баримт, видео, бусад мэдээллийг авах боломжтой. Мөн уг хуудсанд Диснейн “Өөрчлөлтийн төлөөх зоос”-ын дэмжлэгтэйгээр хийсэн хүрээлэн буй орчны боловсролд зориулсан тусгай булан байх болно. Бөхөнгийн нөөцийн төв веб хуудас нь Англи болон Орос гэсэн хоёр хэлээр байх бөгөөд хэрвээ бидэнд илүү мөнгө

олдвол орос хэл дээрх мэдээллийн хэмжээг ихэсгэж, бөхөнгийн тархац нутаг дээр ашиглагддаг бусад хэл рүү орчуулах боломж байгаа гэдэгт бид итгэлтэй байна.

Мэдээллийн сан болох Бөхөнгийн нөөцийн төв веб сайт нь цөөн хэдэн долоо хоногийн дараагаар ажиллаж эхлэнэ. Энэ хугацаанд бид мэдээллийн санд илүү дэлгэрэнгүй мэдээлэл оруулахын тулд Төсөл ба Судлаач маягтыг бөглөхийг бөхөнгийн судалгаа хийж буй хүн бүрээс хүсэх болно. Та бүхэн эдгээр маягтуудыг <http://www.saiga-conservation.com/saiga-resource-centre.html> болон Алыона Шмаленко, alyona.shmalenko@acbk.kz хаягаар хүлээн авч болно.

Бөхөн хамгаалах нийгэмлэгтэй хамтран веб хуудсанд байршуулах материалыг цуглуулж байгаа Адам Филипсонтой adphil100@yahoo.com хаягаар холбогдон Бөхөнгийн нөөцийн төв рүү илгээхээр төлөвлөж байгаа ямар нэгэн баримт, зургууд, бусад материалыг илгээнэ үү.

Бөхөн хамгаалах зорилгоор ажиллаж байгаа бүх хүмүүс бөхөн хамгааллыг дээшлүүлэхийн тулд мэдээлэл солилцон, ОУДХАХ-ийг хэрэгжилтийг дэмжиж буй уг ажилд хамтран оролцох болно гэдэгт бид итгэлтэй байна.



Хийгдэж буй Бөхөнгийн нөөцийн төвийн хуудасны нүүр хуудас.



Талархал

Бөхөн хамгаалах нийгэмлэг сүүлийн 6 сарын турш бидний үйл ажиллагааг дэмжсэн дараах хувь хүмүүст чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна: Маржорие Паркер, Линда Табор-Бек, Стевен болон Карин Чейс, Кеннон болон Боб Худсон, Сюзан болон Куртис Комбс, Жефф Флокен (Амьтны сайн сайхан байдлыг хангах олон улсын сан) IFAW, Чип Овен, Ким болон Кевин Ныканен, Брэд Робертс ба Анне Марие Бургойне, Тайеен Гасте, Лиза & Белинда Тукер, Деборах Чорнейко, Сюзанне Вайтинг, Петер Желинек, Ада вон Тиарнер, Гавин Эванс. Биднийг дэмжиж, зөвлөж байсан Зэрлэг амьтныг хамгаалах сүлжээний ажилтан, сайн дурынханд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний үзэсгэлэнгийн долоо хоногийн зургийг олон жилийн турш аван Бөхөнгийн мэдээ сэтгүүлд гаргах боломжийг олгож буй гайхалтай гэрэл зурагчин Мартин Варонд онцгойлон талархаж байна. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн цоо шинэ электрон сонин болох Бөхөнгийн гэгээ сонинг бүтээхэд өгөөмрөөр тусалсан график дизайнер Майк Бромбергт чин сэтгэлээсээ талархаж байна.

Сэтгүүлийн энэ дугаарыг гаргахад дэмжлэг үзүүлсэн Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар зэрэг байгууллагуудад талархлаа илэрхийлье.

Редакторын баг. Хятад: А. Канг (akang@wcs.org) & Фенглиан Ли (fli@wcs.org), Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар; Казахстан: профессор А. Бекенов & доктор Ю.А. Грачев, Амьтан судлалын хүрээлэн (teriologi@mail.ru), О. Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (olga.klimanova@acbk.kz); Монгол: доктор Б. Лхагвасүрэн (lkhagvasuren@wwf.panda.org) & Б. Чимэддорж, (chimeddorj@wwf.panda.org), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (kalmisaigak@elista.ru) & доктор А. Лушекина, Экологи & Эволюцийн хүрээлэн (saigak@hotmail.com); Узбекистан: Е. Быкова [Гүйцэтгэх редактор] & доктор А. Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: профессор Е.Ж. Милнер-Гулланд [Зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бүх өгүүллийг бидний хэрэглэгдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Жилд сэтгүүлийн хоёр дугаар хэвлэн гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл сэтгүүл хэлбэрээр хүсэлтийн дагуу редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.